



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/539

Улаанбаатар хот

Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй
холбоотой халдварыг тандах
заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.13, 36 дугаар зүйлийг 36.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварыг илрүүлэх тандалтын нийтлэг заавар”-ыг нэгдүгээр, “Мэс заслын дараах шархны халдварыг илрүүлэх тандалтын заавар”-ыг хоёрдугаар, “Судасны гуурстай холбоотой халдвараас сэргийлэх, түүнийг тандах заавар”-ыг гуравдугаар, “Шээлгүүртэй холбоотой шээсний замын халдвар илрүүлэх тандалтын заавар”-ыг дөрөвдүгээр, “Зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушигны хатгаа илрүүлэх тандалтын заавар”-ыг тавдугаар, “Эрсдэлтэй бүлгийн үйлчлүүлэгчид эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар илрүүлэх тандалтын заавар”-ыг зургаадугаар, “Гепатитын В, С вирусийн цочмог халдварын тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээний хамаарлыг тандах заавар”-ыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Энэхүү тушаалаар батлагдсан заавруудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж, ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төрийн болон хувийн хэвшлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Зааврын хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, сургалт зохион байгуулж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү)-д даалгасугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Я.Амаржаргал)-д, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулж, хариуцсан чиг үүргийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Тушаал шинэчлэн батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын “Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой зарим халдварыг илрүүлэх тандалтын заавар батлах тухай” 2019 оны А/74 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д. САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 11 сарын 29 -ны
өдрийн 1539 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХАЛДВАР ИЛРҮҮЛЭХ ТАНДАЛТЫН НИЙТЛЭГ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн байгууллага нь ЭТҮХХ-ыг илрүүлэх бодлого баримталж, эмнэлзүйн шинж тэмдэг ба лабораторит суурилсан, харуулдан тандалт, идэвхитэй (зорилтот) тандалт зэрэг олон аргыг ашиглан халдварыг илрүүлнэ.

1.2. ЭТҮХХ-ыг шинж тэмдгээр тандах тандалтын хуудсыг ашиглан тандалт хийхээс гадна, өөрийн эмнэлгийн үйл ажиллагааны онцлогт тохируулан тандалтын хуудас, судалгааны хуудсыг боловсруулан тандалтад ашиглаж болно.

1.3. Эрүүл мэндийн байгууллага нь тодорхой зорилготойгоор, тандалт, судалгааны арга, аргачлалыг боловсруулан идэвхтэй тандалт, судалгааг жил бүр хийнэ.

1.4. ЭТҮХХ-ын тохиолдлыг илрүүлэн бүртгэн, ажилбар тус бүрийн халдварын түвшинг тогтооно.

1.5. Эрүүл мэндийн байгууллагад дараах тусламж, үйлчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийг ЭТҮХХ-ыг шинж тэмдгээр илрүүлэх тандалтад өдөр тутам хамруулна.

1.5.1. Мэс заслын тусламж авсан үйлчлүүлэгч (зөвхөн сонгосон мэс засал хамаарна);

1.5.2. 48 цагаас дээш судасны гуурстай байсан үйлчлүүлэгч;

1.5.3. 48 цагаас дээш хугацаанд зохиомол амьсгалын аппаратаар дэмжигдсэн үйлчлүүлэгч;

1.5.4. 48 цагаас дээш хугацаанд давсганд шээлгүүр тавиулсан үйлчлүүлэгч.

1.6. Тандалтаар мэс заслын дараах шархны халдвар, судасны гуурстай холбоотой хэсэг газрын халдвар болон үжил халдвар, бактеремия, зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушгины хатгаа, шээлгүүртэй холбоотой шээсний замын халдварын тохиолдлыг илрүүлнэ.

1.7. Тандалтын үргэлжлэх хугацаа нь:

1.7.1. Мэс заслын тусламж, үйлчилгээ авсан бол 30 болон 90 хоногийн дотор, давтан мэс засалд орсон бол хамгийн сүүлд орсон хугацаанаас хойш тооцно;

1.7.2. Судасны гуурс, шээлгүүр тавиулсан, зохиомол амьсгалын аппаратаар дэмжигдсэн үйлчлүүлэгчийг тухайн тусламж, үйлчилгээний хугацаанд нь тандалтад хамруулна.

1.8. Мэс заслын тусламж, үйлчилгээ авсан үйлчлүүлэгч тандалт хийх 30/90 хоногийн хугацаанд боолтын кабинетээр үйлчлүүлэх, харьяа сум, өрх, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээ авсан тохиолдол бүрт тандалт хийнэ.

1.9. Эх, нярайг төрснөөс хойш 30 хоногийн дотор харьяа эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх, эргэлтээр очих тохиолдолд халдвар илрүүлэх тандалт хийнэ. Халдварын сэжигтэй тохиолдлыг бүртгэж, дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ.

1.10. Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчид тусламж үзүүлэх үедээ халдварын шинж тэмдэг илэрч байгаа эсэхийг тандалтын хуудсанд эерэг (+), сөрөг (-) гэсэн тэмдэглэгээгээр тэмдэглэнэ.

1.11. ЭТҮХХ бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллага нь халдварын шалтгааныг тогтоох, эрсдэлт хүчин зүйлийг арилгах, халдвар тархалтыг бууруулахад чиглэсэн хариу арга хэмжээг шуурхай авна.

1.12. Хариу арга хэмжээ авах чадавхи (хүний нөөц, тусламж, үйлчилгээ, оношлуур г.м) хүрэлцээгүй тохиолдолд дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагаас мэргэжлийн туслалцаа дэмжлэг авч ажиллана.

Хоёр. ЭТҮХХ-ын бүртгэл, мэдээлэл

2.1. ЭТҮХХ-ыг сэжигтэй болон батлагдсан гэсэн 2 тохиолдлоор бүртгэнэ. Эмнэлзүй, хамшинжээр оношилсон тохиолдлыг “Сэжигтэй тохиолдол”-оор, тархвар судлалын судалгаа, эмнэлзүй, лабораториор оношилсон тохиолдлыг “Батлагдсан тохиолдол”-оор бүртгэнэ.

2.2. Эмнэлзүйн шинж тэмдэг тохиолдлын тодорхойлолттой нийцэж байвал лабораторийн шинжилгээний дүн хамаарахгүйгээр “Батлагдсан тохиолдол”-оор бүртгэнэ.

2.3. ЭТҮХХ-ын мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийх:

2.3.1. Мэс заслын тусламж авсан, шээлгүүр, судасны гуурс тавиулсан, зохиомол амьсгалын аппаратаар дэмжигдсэн үйлчлүүлэгч бүрт тохиолдлын тодорхойлолтод нийцсэн халдварын тохиолдлын мэдээг цуглуулна.

2.3.2. Халдварт өртөлтийн түвшинг тооцохдоо ЭТҮХХ-т өртсөн үйлчлүүлэгчийн тоог тухайн сард (жилийн тайлан гаргаж байгаа бол жилийн хугацаанд) ижил тусламж, үйлчилгээ, ажилбар хийлгэсэн нийт үйлчлүүлэгчийн тоонд харьцуулж гаргана.

2.4. ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг “ЭТҮХХ-ын тохиолдлыг мэдээлэх схем”-ийн дагуу дээд шатны эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ.

2.4.1. ЭТҮХХ-ын батлагдсан тохиолдлыг “ЭТҮХХ-ын тархвар судалгааны хуудас”-аар, сэжигтэй тохиолдлыг “Хүснэгт 2”-ийн дагуу бүртгэж сар бүр аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт, аймаг нийслэлийн ЭМГ, ЭМТ-өөс ХӨСҮТ-ийн тандалт, судалгааны албанд цаасаар эсвэл ipc@nccd.gov.mn цахим хаягаар мэдээлнэ.

2.4.2. Нэг ижил тусламж, үйлчилгээ авсан 2-оос дээш үйлчлүүлэгч ижил шинж тэмдэг бүхий ЭТҮХХ-т өртсөн, түүний улмаас үйлчлүүлэгч нас барсан 1 тохиолдол гарсан бол онош батлагдахыг хүлээхгүйгээр 24 цагийн дотор яаралтай мэдээлнэ.

2.5. Эрүүл мэндийн байгууллага нь тандалтаар илрүүлсэн ЭТҮХХ-ын тохиолдлын бүртгэл, мэдээллийн сантай байна.

2.6. ЭТҮХХ-ын батлагдсан тохиолдлын оношийг “Өвчний олон улсын 10 дугаар ангилал”-ын дагуу мэдээлнэ.

Гурав. Хариу арга хэмжээ

3.1. ЭТҮХХ-ыг тохиолдлын тодорхойлолтод нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийнэ.

3.2. ХСХ-ын баг/алба нь халдварын шалтгааныг тогтоох, эрсдэлт хүчин зүйлсийг арилгах, халдвар тархалтыг бууруулахад чиглэгдсэн хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3. ЭТҮХХ-ыг үүсгэж байгаа үүсгэгч, түүний эмэнд тэсвэржилтийн байдалд судалгааг хийнэ.

3.4. ЭТҮХХ гарахад нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийн үнэлгээ, дотоод хяналт, тандалтыг сайжруулна.

3.5. ЭТҮХХ-ын эрсдлийг илрүүлж, эрсдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөж ажиллана.

3.6. ЭТҮХХ гарах эрсдлийг бууруулахад шаардлагатай нөөц хангамжийг сайжруулах, удирдлага, зохион байгуулалтаар хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дөрөв. ЭТҮХХ-ын тайлан, мэдээ

4.1. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд ЭТҮХХ-ын тохиолдлын мэдээг өссөн дүнгээр жилийн тайланг гаргана. Аймаг нийслэлийн ЭМГ харьяа байгууллагын тайланг нэгтгэн ХӨСҮТ-д дараа жилийн нэгдүгээр сард ирүүлнэ.

4.2. Эрүүл мэндийн байгууллага сар бүр “Хүснэгт 1”-ийн дагуу ЭТҮХХ-ын тандалтын мэдээг, “Хүснэгт 2” –ын дагуу ЭТҮХХ-ын сэжигтэй тохиолдлыг, “Хүснэгт 3,4”-ын дагуу өртөлт, дундаж хатгалтын мэдээг ipc@nccd.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

4.3. Эмнэлгийн ажилтны дундах цусаар дамжих халдварын байдал, ариутгал, халдваргүйжүүлэлтэд хэрэглэж байгаа тоног, төхөөрөмж, бодисын судалгааг “Хүснэгт 5, 6, 7”-ын дагуу жилд 1 удаа ирүүлнэ.

4.4. ЭТҮХХ-ын мэдээг нэгтгэн дүн шинжилгээ хийн дараа жилийн 2 дугаар сард багтааж эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад эргэн мэдээлнэ.

4.5. Эрүүл мэндийн байгууллага нь жилийн хугацаанд ХСХ-ыг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайланг мэдээллийн урсгалын дагуу дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад жилд 1 удаа тайлагнана.

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 10 сарын 29 -ны
өдрийн 2/539 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт.

МЭС ЗАСЛЫН ДАРААХ ШАРХНЫ ХАЛДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ ТАНДАЛТЫН ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Мэс заслын дараах шархны халдварыг байршлаас нь хамаарч 3 ангилна. Үүнд:
- 1.1.1. Мэс заслын зүслэгийн өнгөц хэсэгт үүссэн шархны халдвар;
 - 1.1.2. Мэс заслын зүслэгийн гүний хэсэгт үүссэн халдвар;
 - 1.1.3. Мэс заслын дараа эрхтэн, эрхтэн хоорондын зайд үүссэн халдвар.
- 1.2. Мэс заслын дараах шархны халдварын тохиолдлын тодорхойлолт:

Хугацаа, хамрах талбай, бүртгэх шалгуур	Үйлчлүүлэгчид илрэх шинж тэмдэг, бүртгэх шалгуур
1. “Мэс заслын зүслэгийн өнгөц хэсэгт үүссэн шархны халдвар” гэдэг нь:	
<p>Мэс засал хийснээс хойш 30 хоног дотор, зүслэг хийсэн талбайн арьс болон арьсан доогуурх эдийг хамарсан халдварын шалтгаант эмгэг өөрчлөлтийг хэлнэ.</p> <p>Дараах тохиолдлоос 1 буюу түүнээс дээш тохиолдол бүртгэгдвэл мэс заслын зүслэгийн өнгөц хэсэгт үүссэн шархны халдвараар бүртгэнэ.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Үжлийн эсрэг дэглэмийг баримтлан арьсан доогуурх эдээс авсан шинжилгээнд нян өсгөвөрлөгдөх; ✓ Нян өсгөвөрлөгдөөгүй ч эмч шархыг зориудаар нээсэн; ✓ Эмч мэс заслын дараах шархны өнгөц хэсэгт үүссэн халдвар гэж оношилсон; 	<p>Үйлчлүүлэгчид дараах шинж тэмдгээс 1 буюу түүнээс дээш шинж тэмдэг илэрвэл мэс заслын зүслэгийн өнгөц хэсэгт үүссэн шархны халдвараар бүртгэнэ.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Шархнаас идээ, үрэвслийн шингэн гарах; ✓ Шарх өвдөж, эмзэглэлтэй болох ✓ Зүслэг орчим хэсэг газарт хавдах; ✓ Зүслэг орчим улайх, халуу оргих;
2. “Мэс заслын зүслэгийн гүний хэсэгт үүссэн шархны халдвар” гэдэг нь:	
<p>Мэсзасал хийлгэснээс хойш 30 болон 90 хоног*дотор зүслэгийн гүний зөөлөн эд фасци, булчингийн давхаргыг хамарсан халдварын шалтгаант эмгэг өөрчлөлтийг хэлнэ.</p> <p>Дараах тохиолдлоос 1 буюу түүнээс дээш тохиолдол бүртгэгдвэл мэс заслын зүслэгийн гүний хэсэгт үүссэн шархны халдвараар бүртгэнэ.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Эмч мэс заслын дараах шархны гүний 	<p>Үйлчлүүлэгчид дараах шинж тэмдгээс 1 ба түүнээс дээш шинж тэмдэг илрэх:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Зүслэгийн гүний хэсгээс идээ гарах; ✓ Гүний хэсэгт тавьсан урсгуур, гуурсаар идээ гарах; ✓ Шарх задрах;

<p>хэсэгт үүссэн халдвар гэж оношилсон;</p> <p>✓ Эмч шархыг зориудаар нээсэн;</p> <p><i>*Мэс заслын төрлөөс хамаарч тандалт хийх хугацаа 30 эсвэл 90 хоног гэх мэт өөр байна. 2.3 дахь заалтыг харах</i></p>	
<p>3. “Мэс заслын дараах эрхтэн, эрхтэн хоорондын зайд үүссэн халдвар” гэдэг нь:</p>	
<p>Мэс заслын дараа 30 эсвэл 90 хоногийн дотор илрэх халдвар орох ба эрхтэнд болон эрхтэн хоорондын хөндийд үүссэн халдварын шалтгаант эмгэг өөрчлөлтийг хэлнэ.</p> <p>Дараах тохиолдлоос 1 буюу түүнээс дээш тохиолдол бүртгэгдвэл мэс заслын дараа эрхтэн, эрхтэн хоорондын зайд үүссэн халдвараар бүртгэнэ.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Эрхтэн, хөндийн эд, шингэнээс нян өсгөвөрлөгдөх; ✓ Халдварын шалтгаанаар давтан мэс засалд орсон; <p>Эмч оношилсон;</p>	<p>Өвчтөнд дараах шинж тэмдэгээс 1 ба түүнээс дээш шинж тэмдэг илрэх:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Эрхтэн, хөндийд тавьсан урсгуур гуурсаар идээ гарах (нээлттэй, хаалттай урсгуур гуурс, Э гуурс, СТ чиглүүлэгч гуурс гм); ✓ Эд, эсийн шинжилгээ, дүрс оношилгоо, багажийн шинжилгээнд буглаа болон халдварын бусад шинж илрэх;

Хоёр. Мэс заслын дараах шархны халдварыг тандах аргачлал, хугацаа

2.1. Мэс заслын дараах шархны халдвар илрүүлэх тандалтыг мэс засал хийсэн эрүүл мэндийн байгууллага, эмнэлгээс гарсны дараа харьяа өрх, сум, дүүргийн эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв болон үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлж буй өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага хийнэ.

2.2. Мэс заслын тусламж, үйлчилгээ авсан үйлчлүүлэгчид халдвар илрүүлэх тандалтыг мэс засалд орсноос хойш 24 цагаас эхлэн хийнэ.

2.3. Мэс заслын дараа шархны халдварын шинж тэмдэг илрэх хугацаа өөр байдаг тул тандалтын үргэлжлэх хугацаа нь мэс заслын төрлөөс хамаарч харилцан адилгүй байна.

2.3.1. Мэс засал хийлгэснээс хойш 30 хоногийн хугацаанд тандалт хийх мэс заслын нэр

30 хоногийн хугацаанд тандалт хийх мэс заслын нэр	
1	Хэвлийн хөндийн цүлхэн хавчих
2	Мөч тайрах мэс засал
3	Мухар олгойн мэс засал
4	Диализ хийх зорилгоор шунт тавих
5	Цөсний зам, элэг, нойр булчирхай
6	Гүрээний артерийн судасны дотор талыг тайрах мэс засал
7	Цөсний мэс засал
8	Бүдүүн гэдэсний мэс засал
9	Кесар мэс засал
10	Ходоодны мэс засал

11	Зүрх шилжүүлэн сулгах
12	Хэвлийн хөндийгөөр умай тайрах мэс засал
13	Бөөр шилжүүлэн суулгах
14	Нурууны зөөлөн эдийг тайрах мэс засал
15	Элэг шилжүүлэн суулгах
16	Хүзүүний мэс засал
17	Бөөрний мэс засал
18	Өндгөвчний мэс засал
19	Түрүү булчирхайн мэс засал
20	Шулуун гэдэсний мэс засал
21	Жижиг гэдэсний мэс засал
22	Дэлүүний мэс засал
23	Цээжний мэс засал
24	Бамбай булчирхайн мэс засал
25	Үтрээгээр умай тайрах мэс засал
26	Оношилгооны зорилгоор хэвлийн хөндий нээх

2.3.2. Мэс засал хийлгэснээс хойш 90 хоногийн хугацаанд тандалт хийх мэс заслын нэр.

90 хоногийн хугацаанд тандалт хийх мэс заслын нэр	
1	Хөхний мэс засал
2	Зүрхний мэс засал
3	Зүрхний титэм судас залгах шунт мэс заслын үед цээжний болон дотор талын зүсэлт
4	Тархины мэс засал
5	Нугас, нурууны бэхэлгээ
6	Хугарлын нээлттэй багасгах мэсзасал
7	Ивэрхийн мэсзасал
8	Түнхний хиймэл үе протез
9	Өвдөгний үе солих мэс засал
10	Пейсмикер тавих
11	Захын судасны мэс засал
12	Нугас, нуруунд дахин бэхэлгээ хийх
13	Ховдолд шунт тавих

2.4. Үйлчлүүлэгч тандалтын хугацаанд давтан мэс засалд орсон бол давтан мэс засалд орсон өдрөөс хойш тандалтыг үргэлжлүүлэн хийнэ.

2.5. Мэс заслын дараах шархны халдварыг илрүүлэхдээ дараах аргуудыг хэрэглэнэ. Үүнд:

2.5.1. Шууд ажиглах арга - Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад эмнэлгийн мэргэжилтэн “шархыг шууд ажиглах” байдлаар харж тохиолдлын тодорхойлолтод заагдсан халдварын шинж тэмдгийг илрүүлнэ.

2.5.2. Шууд бус арга - Үзлэгийн карт, тандалтын хуудас, сувилагчийн тэмдэглэл, нян судлалын лабораторийн шинжилгээний бүртгэл, халууны хуудас, антибиотикийн хэрэглээ, мэс заслын тэмдэглэл, өвчний онош, эмчилгээний хуудас, эргэж хэвтсэн болон давтан хагалгааны бүртгэл зэрэг бусад холбогдох баримт бичгийн эх сурвалжуудаас илрүүлнэ.

2.6. Мэс засал хийгдсэн үйлчлүүлэгчид шууд ажиглах аргаар шархны халдварыг илрүүлэх тандалтыг хийж “Мэс заслын дараах шархны халдварыг шинж тэмдгээр тандах хуудас”-ыг хөтөлнө.

2.7. Мэс заслын шархны халдварыг дараах байдлаар бүртгэнэ. Үүнд:

2.7.1. Мэс заслын дараах шархны халдварын тохиолдлын тодорхойлолтод заасны дагуу зүслэгийн өнгөц, гүний, эрхтэн, эрхтэн хоорондын халдвараар;

2.7.2. Мэс заслын дараах шархны халдварын тохиолдол нь халдварын эхэн үед зүслэгийн өнгөц хэсгийн халдвар байгаад дараагийн хоногуудад зүслэгийн гүний хэсгийг хамарсан шархны халдварын шалгуурт тохирч байвал тухайн тохиолдлыг зүслэгийн гүний хамарсан шархны халдвараар;

2.7.3. Анхдагчаар зүссэн олон зүслэгтэй мэс заслын шарх халдварлагдсан бол зөвхөн нэг тохиолдлоор;

2.7.4. Анхдагчаар зүссэн олон зүслэгтэй мэс заслын шарх халдварлагдсан бол (өнгөц, гүний зүслэгийн, эрхтэн, хөндийн) хамгийн гүн эдийн түвшинг хамарсан халдварын тохиолдлоор бүртгэнэ. Жишээ нь. Хэвлийн хөндийн дурангийн нэг зүслэг нь өнгөц зүслэгийн, нөгөө зүслэг нь гүн зүслэгийн мэс заслын шархны халдварын шалгуурт тохирч байвал зөвхөн гүн зүслэгийн шархны халдварын нэг тохиолдол;

2.7.5. Халдварын оношийг “Өвчний олон улсын 10 дугаар ангилал”-ын дагуу бүртгэнэ.

2.7.6. Мэс заслын дараах шархны халдвар нь үе, холбогч эд, өөхөн эд, ясны идээт үрэвсэл, үжил халдвараар хүндэрсэн бол хүндрэлийн оношийг давхар бүртгэнэ.

2.8. Мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллага нь жилд 1-ээс доошгүй удаа мэс заслын дараах шархны халдварыг илрүүлэх идэвхитэй тандалт, судалгаа хийнэ.

2.9. Эрүүл мэндийн байгууллага нь сар тутам мэс заслын тусламж, үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн тоо, мэс заслын дараах шархны халдварын тохиолдлын тоог цуглуулж, шархны халдварын түвшинг мэс засал тус бүрээр тооцож гаргана.

2.10. Халдварын түвшинг тооцохдоо мэс заслын дараах шархны халдварын тохиолдлын тоог, тухайн мэс засалд орсон нийт үйлчлүүлэгчийн тоонд харьцуулж 100 мэс засал тутамд тооцож гаргана.

2.11. Тандалт хийх явцад халдварын шинж тэмдэг илрэх, эсвэл халдвар илрүүлэх зорилтод тандалт, судалгаа хийж байгаа үед шинжлэгдэхүүн авч нян судлалын лабораторид хүргүүлнэ.

Гурав. Мэс заслын тусламж, үйлчилгээ авсан үйлчлүүлэгчид шархны халдварын эрсдлийн индексийг үнэлэх

3.1. Эрсдлийн индексийг мэс заслын үргэлжлэх хугацаа, “ASA” ангиллын оноо, шархны ангиллын онооны нийлбэрээр тооцож гаргана. Эрсдлийн индексийн оноо өндөр байх нь шарх халдварлах эрсдэлтэй байгааг харуулна.

3.2. Мэс заслын үргэлжлэх хугацаа гэдэг нь мэс засал эхэлснээс дуусах хүртэлх хугацааг хамруулдаг. Эхлэх хугацаанд зүслэг хийж эхэлсэн хугацааг, дуусах хугацаанд үйлчлүүлэгчид ажилбар бүрэн хийж дууссан хугацааг оруулах ба боолт, гуурсыг тавьж бэхэлгээг хийсэн, хэрэглэсэн материал тоологдож хянагдаж дууссан хугацаагаар авна. Тухайн мэс заслын үргэлжлэх хугацаа их бол 1, бага бол 0 оноотой байна.

3.3. Үйлчлүүлэгчийн биеийн байдалд дараахь байдлаар үнэлгээ өгнө.

“ASA”-ын ангилал

Ангилал	Хагалгааны өмнөх үеийн өвчтөний биеийн байдал	Эрсдлийн оноо
A 1	Эрүүл, биеийн байдал хэвийн байгаа үйлчлүүлэгч	0
A 2	Хөнгөн хэлбэрийн эмгэгтэй үйлчлүүлэгч	0
A 3	Эрхтэн системийн хүнд хэлбэрийн өвчтэй хөдөлмөрийн чадвар алдаагүй үйлчлүүлэгч	1
A 4	Амь насанд нь заналхийлж байгаа эрхтэн тогтолцооныхүнд хэлбэрийн эмгэгтэй үйлчлүүлэгч	1
A 5	Мэс засал хийсэн, хийгээгүй аль ч тохиолдолд 24 цагаас дээш хугацаагаар амьдрах магадлалгүй үйлчлүүлэгч	1

3.4. Мэс заслын шархны ангиллыг 4 зэрэгт хуваана.

W1 Цэвэр шарх	Хоол боловсруулах, амьсгалын, шээс бэлгийн замын эрхтнүүдэд хийгдэх мэс засал, ил гэмтлийн мэс заслаас бусад мэс засал орно. Шарх нь анхдагчаар эдгэрсэн цэвэр, хаалттай урсгуур, гуурстай болон битүү гэмтлийн шарх энэ ангилалд орж болно.	0
W2 Цэвэр бохирлогдсон шарх	Хоол боловсруулах, амьсгал, шээс, бэлгийн замын эрхтнүүдэд хийгдсэн бохирлогдоогүй мэс засал орно. Тухайлбал мэс заслын техник алдагдаагүй цөс, мухар олгой, үтрээ, залгиурын мэс засал орно.	0
W3 Бохирлогдсон шарх	Нээлттэй шинэ гэмтлийн шарх. Мэс заслын техник алдагдсан (зүрхний нээлттэй иллэг гэх мэт) хоол боловсруулах замаас шингэн гарсан, идээт үрэвсэлгүй, урсгуур болон эдэд идээт үрэвсэлгүй шарх энэ ангилалд багтана.	1

W4 Бохирдож халдварлагдсан	Хуучин гэмтлийн шарх, эд гэмтсэн, эмнэлзүйн шинж тэмдгээр халдварлагдсан шарх орно.	1
---	---	---

3.5. Шархны ангилал W3, W4, ASA-ын ангиллаар A3, A4, A5, зэрэгтэй мэс заслын үргэлжлэх хугацаа их байх нь шархны халдварын эрсдлийг нэмэгдүүлдэг.

Дөрөв. Мэс заслын дараахь шархны халдварын эрсдэлт хүчин зүйл, халдвараас сэргийлэх арга хэмжээ

4.1. Үйлчлүүлэгчийн зүгээс нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл, халдвараас сэргийлэх:

4.1.1. **Сахарын хэмжээ:** Мэс заслын өмнө болон дараа цусан дахь сахарын хэмжээг хянаж байх хэрэгтэй. Мэс заслын дараа 48 цагийн дотор цусан дахь сахарын хэмжээ 200 mg/dL-ээс их болоход мэс заслын шархны халдвар ихсэх хамааралтай.

4.1.2. **Тамхины хэрэглээ:** мэс заслын шархны эдгэрэлтийг удаашруулдаг бөгөөд зүрхний мэс заслын дараа тамхи татах нь мэс заслын дараах өвчүүний болон голтын халдвар үүсэхэд нөлөөлдөг биеэ даасан шалтгаан болдог.

4.1.3. **Дааврын эмчилгээ:** Мэс заслын өмнө даавар болон дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэсэн бол мэс заслын шархны халдварт нөлөөлөх магадлалтай.

4.1.4. **Хүнс тэжээлийн дутагдал:** Зарим төрлийн мэс засалд хоол хүнсэнд агуулагдах уураг, илчлэг чанарын дутагдал нь шархны эдгэрэлтэнд нөлөөлдөг.

4.1.5. **Мэс заслын өмнө эмнэлэгт хэвтсэн хугацаа:** Мэс заслын өмнө өвчтөн эмнэлэгт олон хоног хэвтэх нь мэс заслын шархны халдварын эрсдлийг нэмэгдүүлдэг.

4.1.6. **Нян тээгч:** *Стафилококк ауреус* нь мэс заслын шархны халдварын түгээмэл үүсгэгч бөгөөд үйлчлүүлэгчийн хамар, хоолойгоос тогтмол илрэх нь шарх халдварлах эрсдлийг нэмэгдүүлдэг.

4.1.7. **Мэс заслын өмнөх цус сэлбэлт:** Мэс заслын өмнө цус сэлбэх нь мэс заслын дараах нянгийн халдварыг нэмэгдүүлдэг.

4.1.8. **Мэс заслын өмнө усанд орохгүй арьсны бохирдол их байх:** Шархны халдварын эрсдлийг нэмэгдүүлдэг. Мэс заслын өмнө усанд орох, антисептик уусмал ашиглах нь арьсан дээрх нянгийн тоог багасгадаг.

4.2. Эрүүл мэндийн байгууллагын зүгээс нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл, халдвараас сэргийлэх:

4.2.1. **Антибиотик урьдчилан сэргийлэлт:** Мэс заслын үед халдварлагдах нянгийн тоог бууруулах зорилгоор мэс заслын үед захын цусанд хамгийн өндөр түвшрүүлэгтэй байх хугацаа, тунг тооцож өргөн хүрээний үйлчилгээтэй антибиотикийг зүслэг эхлэхийн өмнө судсаар цохилтын тунгаар хийнэ. Мэс заслын өмнө антибиотик эмчилгээ хийлгэсэн бол шаардлагагүй.

4.2.2. **Мэс заслын өмнөх үс хусалт:** Мэс заслын өмнө үс авах нь мэс заслын шархны халдварыг нэмэгдүүлдэг бөгөөд зайлшгүй шаардлагатай бол хайчаар тайрч авах эсвэл электрон үсний машинаар авна.

4.2.3. **Мэс заслын өмнөх талбайн халдваргүйжүүлэлт хангалтгүй:** Талбайн халдваргүйжүүлэлтийг повидион иод, хлоргексидин, спирт агуулсан уусмалуудаар хийнэ.

4.2.4. **Мэс заслын багийн хагалгааны өмнөх гар угаалт:** Мэс заслын багийн гишүүд ариун хувцас, бээлийгээ өмсөхийн өмнө гар болон бугуйгаа угаана. Мэс заслын гар угаалтад өргөн хүрээний, богино хугацаанд идэвхтэй үйлчилгээ үзүүлдэг спирт, хлоргексидин, повидион иод, триклосон агуулсан уусмалыг хэрэглэнэ. Мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн ажилтан хиймэл хумс хэрэглэх, хумс ургуулах, будах, бөгж, гоёл чимэглэл зүүхгүй, мэс заслын үед утсаар ярихыг хориглоно.

4.2.5. **Мэс заслын багийн гишүүдийн эрүүл мэндийн байдал:** Мэс заслын багийн гишүүн нян, вирус тээгч бол мэс заслын явцад халдвараас сэргийлэх дэглэм алдагдсан, хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмсөөгүй зэрэг тохиолдолдүйлчлүүлэгчид халдвар дамжих эрсдэлтэй. Үйлчлүүлэгч халдвар авах эрсдлээс сэргийлж эмнэлгийн ажилтанг эрүүлжүүлэх, эмчилгээ хийх, хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмсөнө.

4.2.6. **Мэс заслын өрөөний агааржуулалт:** Мэс заслын өрөөний агаар амьсгалын шүүрэл, арьсны гуужсан эд, тоосонцор, бичил биетнээр бохирдсон байдаг. Иймд:

- 4.2.6.1. Мэс заслын өрөөний бичил биетний түвшин өрөөн дэх хүмүүсийн тоо хөдөлгөөнтэй шууд хамааралтай тул мэс заслын үед хөл хөдөлгөөнийг хамгийн бага байлгах;
- 4.2.6.2. Мэс заслын өрөө агаарын эерэг даралттай байх ба агаарын урсгал нь цэврээс бохир хэсэг рүү шилжихээр зохион байгуулах;
- 4.2.6.3. Мэс заслын өрөөний агааржуулалтын систем нь 2 шүүлтүүртэй байх ба эхний шүүлтүүр нь 30% дээш, 2 дох шүүлтүүр нь 90% аас дээш агаарыг шүүх чадалтай байх;
- 4.2.6.4. Мэс заслын өрөөний агааржуулалтын систем цагт хамгийн багадаа 15 удаа агаар сэлгэлтийг хийж агаарыг цэвэршүүлж оруулдаг байх;
- 4.2.6.5. Агаарыг таазнаас оруулах ба шалны ойролцоогоос бохир агаарыг гаргадаг байх;
- 4.2.6.6. Мэс заслын өрөөний хэт ягаан туяаг нэмэлтээр ажиллуулах ба мэс заслын шархны халдварын эрсдлийг бууруулдаг.

4.2.7. **Мэс заслын өрөөний орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт:** Мэс заслын өрөөний орчны гадаргуу цэвэр биш байх нь (ширээ, шал, хана, тааз, гэрэлтүүлэггэхмэт) мэс заслын шархны халдварыг нэмэгдүүлэх эмгэг төрөгчийн эх үүсвэр болдог. Тиймээс мэс засал болгоны дараа цэвэрлэж байх нь чухал.

4.2.8. **Мэс заслын багажийн ариун байдал:** Дутуу ариутгасан багаж, ариун байдал алдагдсан багаж мэс засалд хэрэглэх нь шарххалдварлуулна. Мэс заслын хувцас, даавуун хэрэгслийг аль болох нэг удаагаар хэрэглэнэ.

4.2.9. **Мэс заслын техник, үжлийн эсрэг дэглэм:**

- 4.2.9.1. Мэс заслын техник, мэс засалчийн ур чадвар сайн байх нь мэс заслын шархны халдварыг бууруулдаг.
- 4.2.9.2. Мэс заслын явцад биед ямар нэгэн гадны биет үлдээх, оёдлын утас, хиймэл эрхтэн, гуурс, бусад халдварлагдсан эд материал нь мэс заслын дараах шархны халдварыг ихэсгэнэ.
- 4.2.9.3. Мэс заслын үед зүслэгт урсгуур тавих нь мэс заслын зүслэгийн шархны халдварын эрсдлийг ихэсгэдэг. Урсгуур гуурсыг мэс

заслын зүслэгээс хол тусгаарлаж тавих нь халдварын эрсдлийг бууруулна.

4.2.9.4. Хаалттай урсгуур гуурс нь нээлттэй урсгуур гуурсыг бодвол мэс заслын шархны эрсдлийг бууруулна. Урсгуур гуурсыг удаан байлгах нь нянгаар халдварлагдах эрсдэлтэй.

4.2.9.5. Мэс заслын дараах шархны арчилгаа шарх анхдагчаар эдгэхэд нөлөөлнө. Мэс заслын дараа 24-48 цагийн дараа боолтыг сольж ариун боолт хийнэ.

Маягт 1

Мэс заслын дараах шархны халдварын тархвар судалгааны хуудас

Овог, нэр		Регистерийн дугаар:	
Хүйс:	Эм Эр	Төрсөн он сар өдөр:	
Эмнэлэгт хэвтсэн он сар өдөр:		Халдварын тохиолдлыг бүртгэсэн он сар өдөр:	
Мэс засал хийсэн он сар өдөр		Өвчний олон улсын 9-р ангилалын үйлдлийн онош:	
МЗДШХ-ын төрөл:			
<input type="checkbox"/> Анхдагч өнгөц зүслэгийн		<input type="checkbox"/> Анхдагч гүний зүслэгийн	
<input type="checkbox"/> Хоёрдогч өнгөц зүслэгийн		<input type="checkbox"/> Гүний хоёрдогч зүслэгийн	
<input type="checkbox"/> Эрхтэн/хөндийн(байрлал) _____			
Мэс заслын үед халдвар илэрсэн:		<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
Шалгуур (холбогдох нүднүүдийг заах)			
<u>Шинж тэмдэг</u>		<u>Лабораторийн шинжилгээ</u>	
<input type="checkbox"/> Урсгуур гуурс эсвэл материал	<input type="checkbox"/> Хамрын хөндийн үрэвсэл	<input type="checkbox"/> Бичил биетэн илэрсэн	
<input type="checkbox"/> Хавдсан эсвэл нэвчдэс	<input type="checkbox"/> Арпеа	<input type="checkbox"/> Цусны ариун чанарын шинжилгээгээр бичил биетэн илэрсэн	
<input type="checkbox"/> Улайсан	<input type="checkbox"/> Зүрхний хэм удаашрах	<input type="checkbox"/> Тусдаа авсан эд эсвэл шингэний шинжлэгдэхүүнд ≥ 2 дээш бичил биетэн илэрсэн	
<input type="checkbox"/> Халуун оргих	<input type="checkbox"/> Нойрмог болох		
<input type="checkbox"/> Халуурсан	<input type="checkbox"/> Ханиалгах	<input type="checkbox"/> Бусад лабораторийн шинжилгээгээр эерэг	
<input type="checkbox"/> Шархыг зориудаар нээсэн/ урсгуур	<input type="checkbox"/> Дотор муухайрах	<input type="checkbox"/> Дүрс оношилгоогоор халдварыг илрүүлсэн	
<input type="checkbox"/> Шарх аяндаа задарсан	<input type="checkbox"/> Бөөлжих		
<input type="checkbox"/> Буглаа	<input type="checkbox"/> Шээсний хэмжээ багасах	<u>Клиникийн онош</u>	
<input type="checkbox"/> Инвазив процедур, биеийн үзлэг, гистологийн шинжилгээгээр бусад халдварыг илрүүлэх		<input type="checkbox"/> Эмчийн дүгнэлт:	
<input type="checkbox"/> Бусад шинж тэмдэг			
Бусад хүндрэл -----		Эмнэлгээс гарсан он сар өдөр:	

Мэс ажилбарын дараах шархны халдварыг шинж тэмдгээр тандах хуудас

Сар өдөр	Эмчлүүлэгчийн овог, нэр	Мэс ажилбар хийлгэсэн эмнэлгийн нэр	Мэс ажилбар хийлгэсэн огноо	Халдварын шинж тэмдгүүд										Сорьц	Илэрсэн үүсгэгч	Тандалт хийсэн хүний нэр	
				Халуурах	Зүслэг орчмоор улайх	Шарх орчмоор хавагнах	Зүслэг орчмоор халуун оргих	Шарх буглах	Урсгуураар идээ гарах	Шархнаас идээ гарах	Эдийн гүнээс идээ гарах	Шарх өөрөө задрах	Эмч шархыг зориудаар нээх				Бусад

Тайлбар:

1. Тандалтын хуудас бүх шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагад хөтлөгдөнө.
2. Тандалт хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн халдварын шинж тэмдэг илэрч буй тохиолдолд +, илрээгүй бол – тэмдгээр тус тус тэмдэглэнэ.
3. Илэрсэн тохиолдолд тасгийн эрхлэгч эмч, тархвар судлаач, эмнэлгийн даргад мэдээлнэ.

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 11 сарын 29 -ны
өдрийн 1539 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

СУДАСНЫ ГУУРСТАЙ ХОЛБООТОЙ ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ, ТҮҮНИЙГ ТАНДАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Судасны гуурстай холбоотой халдвар (цаашид СГХХ гэх) - гэдэг нь судсанд гуурс тавьснаас хойш 48 цаг болж байгаа үйлчлүүлэгчид өөр байрлалтай халдварын голомт илрээгүй тохиолдолд цусанд эмгэг төрөгч илэрч халдвар, хордлогын шинж илрэхийг хэлнэ.

1.2. СГХХ-ыг байршлаар нь дараах 2 бүлэгт хуваана.

1.2.1. Төвийн судасны гуурстай холбоотой халдвар (цаашид ТСГХХ гэх) - гэдэгт дээд, доод хөндийн тараагуур болон хураагуур судсанд тавигдсан гуурстай холбоотой халдварууд хамаарна.

1.2.2. Захын судасны гуурстай холбоотой халдвар (цаашид ЗСГХХ гэх) - гэдэгт бусад судсанд тавигдсан гуурстай холбоотой халдварууд хамаарагдана.

1.3. Үйлчлүүлэгч нь өөр эмнэлгээс шилжин ирж буй тохиолдолд өмнөх эмнэлэгт гуурс тавьсан өдрөөс эхлэн тооцно.

1.4. СГХХ-г бодит үзлэг, эмнэлзүйн болон лабораторийн дараах шалгуурыг үндэслэн тодорхойлно (Хүснэгт 1).

Судасны гуурстай холбоотой халдварын тодорхойлолт.

Тохиолдлын тодорхойлолт	Лабораторийн шалгуур
<p>Дараахь шинж тэмдгүүдээс аль нэг нь илэрнэ. Шалтгаангүйгээр 38 хэм ба түүнээс дээш халуурах. Артерийн даралт багасах (САД <90 мм рт.ст.) Шээсний гарц багасна (>20 мл/цаг). Судасны цохилт түргэснэ(>90 удаа/мин). Арьсны өнгө өөрчлөгдөж, зэвхий саарал болно.</p> <p>1 хүртэлх насны хүүхдэд аль нэг нь илэрнэ. Шалтгаангүйгээр 38 хэм ба түүнээс дээш халуурах, эсвэл 37 хэмээс бууна. Апноэ эсвэл брадикарди Арьс эрээнтэж, сааралтана. Хоол, хөхөндөө дургүйцнэ Нойрмог, унтаа болно.</p>	<p>Тодорхой байрлалтай халдвар илрээгүй байхад: Цусанд эмгэгтөрөгч бичил биетэн ургана (дээжийг захын судаснаас насанд хүрсэн хүн бол 2 хуруу шилэнд тус бүр 20-30 мл, хүүхэд бол 2-10 мл цусыг авна, өмнө нь арьсыг 2% иодын цэвэр уусмалаар >30 секунд халдваргүйжүүлнэ).</p> <p>Эсвэл</p> <p>Цусанд дараалсан 2 удаагийн бичил амь судлалын шинжилгээгээр арьсны хэвийн бичил биетэн ургах Бичил амь судлалын шинжилгээ хийгдээгүй байхад эмч үжлийн заалтаар бичил биетний эсрэг эмчилгээ хийсний дараа, сорьц буруу авсан, шинжилгээний алдаа зэргээс шинжилгээнд бичил биетэн илрэхгүй байж болно.</p>


Хоёр. Тандалт хийх аргачлал

2.1. Халдварын сэжигтэй тохиолдлыг илрүүлэх тандалтыг “Судасны гуурстай холбоотой халдварыг тандах бүдүүвч”-ийн дагуу бодит үзлэг, эмнэл зүйн болон лабораторийн шалгуурыг үндэслэн судсанд гуурс тавиулсан бүх үйлчлүүлэгчдэд өдөр бүр эмчлэгч эмч, сувилагч хийнэ (Бүдүүвч №1).

2.2. Тандалтыг “Халдварыг шинж тэмдгээр тандах хуудас”-ын дагуу тогтмол хөтөлнө (Хавсралт №1).

Бүдүүвч №1.

Судасны гуурстай холбоотой халдварыг тандах бүдүүвч



Гурав. Эрсдэлт болон халдвараас сэргийлэх хүчин зүйл

3.1. Үйлчлүүлэгчтэй холбоотой СГХХ-ын эрсдэлт хүчин зүйлд дараах нөхцөлүүд хамаарна. Үүнд:

- 3.1.1. Эмнэлэгт олон хоног эмчлүүлсэн
- 3.1.2. Олон хоног судсанд гуурстай байгаа
- 3.1.3. Гуурс байрлуулсан хэсэгт бичил биетний колони ихэссэн
- 3.1.4. Гуурсны гадна хэсэгт бичил биетний колони ихэссэн
- 3.1.5. Гуурсыг гүрээний дотор хураагуур судсанд байршуулсан
- 3.1.6. Гуурсыг цавины хураагуур судсанд байршуулсан (насанд хүрэгсдэд)
- 3.1.7. Нейтропени
- 3.1.8. Дутуу төрсөн
- 3.1.9. Судсаар хооллож байгаа
- 3.1.10. Цус сэлбэсэн (хүүхдэд)

3.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой СГХХ-ын эрсдэлт хүчин зүйлд дараах нөхцөлүүд хамаарна. Үүнд:

- 3.2.1. Эрчимт эмчилгээний тасгийн 1 өвчтөнд ногдох сувилагчийн тоо
- 3.2.2. Судасны гуурсны ашиглалтын эрчим
- 3.2.3. Судасны гуурсны арчилгааны заавар (халдвараас сэргийлэх багц хэрэгжүүлдэг эсэх)
- 3.2.4. Тохиромжгүй орчин, нөхцөл (барилга, инженерийн шугам сүлжээ, агааржуулалт, тоног төхөрөмж, угаалга цэвэрлэгээ, ачаалал, гм)

Дөрөв. Төвийн судасны гуурстай холбоотой халдвараас сэргийлэх

4.1. Төвийн судсанд аль болох гуурс тавихгүй байхыг эрмэлзэх бөгөөд дараах заалтаар гуурс тавина. Үүнд:

- 4.1.1. Цус эргэлтийг хянах
- 4.1.2. Өвчтөний биеийн байдал тогтворгүй байгаа
- 4.1.3. Парентерал тэжээл, цус сэлбэх гэх мэт үргэлжилсэн эмчилгээ хийх
- 4.1.4. Захын венийн судасны хүрц төвөгтэй
- 4.1.5. Судас агшаах эмийн бэлдмэл хэрэглэх

4.2. Төвийн судсанд гуурс тавихад дараах бэлтгэлийн хангана. Үүнд:

4.2.1. Гуурс байршуулах, засах, авах ажилбарыг зориулалтын ажилбар (эрчимт эмчилгээ, мэс засал, яаралтай тусламж)-ын өрөөнд гүйцэтгэнэ.

4.2.2. Ажилбар гүйцэтгэгч нь гуурс байршуулах, засах тохиолдолд туслах болон (3 удаа амжилтгүй хатгалт хийсний дараа гар сольж хийх) зөвлөхтэй хамт ажилбарыг хийнэ.

4.2.3. Төвийн судасны гуурсны багц нь ариун бээлий, халат, малгай, маск, өвчтөний биеийг бүтэн хучих хучаас, халдваргүйжүүлэх бодис, өвчин намдаагч, гуурс, тариур, хямсаа, шархны тунгалаг лент зэргээс бүрдэнэ.

4.2.4. Эмчлүүлэгч эсхүл түүний гэр бүл, асран хамгаалагчаас зөвшөөрөл авч баримтжуулна.

4.3. Төвийн судсанд гуурс тавих ажилбарыг дараах дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

4.3.1. Гарыг савандаж угаагаад дараа нь гарыг 70%-ийн спирт эсвэл 2%-ийн хлоргексидины уусмал (хлоргексидинд харшилтай бол повидон иод)-аар халдваргүйжүүлнэ.

4.3.2. Ажилбар гүйцэтгэгч болон туслах нь ариун бээлий, халат, амны хаалт, малгай өмсөнө. Зөвлөх болон өрөөнд байгаа бусад хүмүүс амны хаалт, малгай өмсөнө.

4.3.3. Гуурсны хүрцийг сонгохдоо боломжтой бол эгэмний доорхи венийг сонгох бөгөөд гүрээний болон гуяны венийг дараагийн сонголт болгон хүрц орчим аливаа шарх, халдварын голомт, судасны нарийсал, бөглөрөлөөс зайлсхийнэ.

4.3.4. Эмчлүүлэгчийг хэвтээ, шаардлагатай бол Трендленбургийн байршилд байршуулна.

4.3.5. Талбайд тэмтрэлт хийж хатгалт хийх газраа тогтоож талбайг халдваргүйжүүлсэний дараа дахин тэмтрэхээс зайлсхийж үжилгүйжүүлэх техникийг баримтлана.

4.3.6. Талбайг 2%-ийн хлоргексидины уусмал (байхгүй бол 2.5-7.5% повидон-иод, 70%-ийн изопропил)-аар 30 секундын турш төвөөс зах руу тойргоор арчин халдваргүйжүүлэн 30 секунд хүлээж хатаана (цавины хүрц бол 2 минут арчиж улмаар 1 минут хатаана).

4.3.7. Эмчлүүлэгчийн биеийг ариун хучаасаар бүрэн хучина.

4.3.8. Хатгалт хийхийн өмнө тавих гэж байгаа гуурсны салаануудыг түр хаана.

4.3.9. Судсанд байршуулах гуурсыг 14 хоногоос удаан хугацаагаар байршуулахаар төлөвлөж байгаа бол антибиотик эсхүл халдваргүйжүүлэх бодис шингээсэн гуурс байршуулна.

4.3.10. Судас тодруулагч ашиглан ариун нөхцөлд судсанд гуурсыг байршуулсны дараа ариун боолт хийж огноогоо тэмдэглэнэ. Боломжтой бол хлоргексидин шингээсэн тунгалаг наалтаар наана.

4.3.11. Гуурсыг бөглөрөхөөс сэргийлж 0.9%-ийн физиологийн уусмалаар, бөглөрөх магадлалтай бол гепарины уусмалаар, халдварын эрсдэлтэй бол антибиотикийн уусмалаар тус тус түгжинэ.

4.3.12. Гуурсны үзүүрийн байршлыг рентгенд харж баталгаажуулна.

4.4. Төвийн судсанд гуурс тавьсан өвчтөний шархыг өдөр тутам хяналтын хуудсаар шалгаж дараах явцын арчилгааг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.4.1. Төвийн судасны гуурс шаардлагатай эсэхийг өдөр бүр үнэлж анхны боломжоор авна.

4.4.2. Эрчимт эмчилгээний тасгийн өвчтөнд өдөр бүр хлоргексидины савантай усаар угаалга хийнэ.

4.4.3. Гуурсыг ашиглах болгондоо тагийг нэг удаагийн тагаар солих ба хавхлага болон уртасгагчийг 2%-ийн хлоргексидины уусмал (байхгүй бол 2.5-7.5% повидон-иод, 70%-ийн изопропил)-аар 15 секундээс багагүй хугацаагаар халдваргүйжүүлнэ.

4.4.4. Боолтыг энгийн ариун самбаагаар хийсэн бол 48 цаг тутамд, тунгалаг наалттай бол 5 хоног тутамд, антибиотик шингээсэн тусгай боолт бол 7 хоног тутамд боолтыг солих ба харин боолт норсон, цус болсон, хууларсан бол тухай бүрт нь боолтыг сольж огноог тэмдэглэнэ.

4.4.5. Хуванцар, шалчийдаг, хаалттай дуслын системийг ашиглана.

4.4.6. Дуслын системээр үргэлжлүүлэн эмчилгээ хийж байгаа тохиолдолд 5 хоног тутамд, цус сэлбэсэн эсхүл судсаар тэжээл хийсэн бол 24 цагийн дотор, пропофол хийсэн бол 6 цагийн дотор системийг сольж дээр нь огноог тэмдэглэнэ.

4.4.7. Гуурсыг авахдаа гүйцэтгэгч нь ариун бээлий, малгай, амны хаалт хэрэглэнэ.

4.5. Төвийн судсанд байршуулсан гуурсыг авах ажилбарыг дараах дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

4.5.1. Гүйцэтгэгч ажилбарын өрөөнд гуурсыг авахдаа ариун бээлий, амны хаалт, малгай өмсөнө.

4.5.2. Гарын ариун цэврийг сахиж, талбайг үжилгүйжүүлэх техникээр халдваргүйжүүлсэний дараа гуурсыг авч ариун боолт хийнэ.

4.5.3. Өвчтөн халдварын эрсдэлтэй эсхүл ямар нэг халдварын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд гуурсны үзүүрээс 5 см зайнд ариун хайчаар хайчлан авч бичил амь судлалын шинжилгээнд илгээнэ.

Тав. Захын судасны гуурстай холбоотой халдвараас сэргийлэх

5.1. Захын судсанд аль болох гуурс буюу уян зүүг тавихгүй байхыг эрмэлзэх бөгөөд дараах заалтаар гуурс тавина. Үүнд:

5.1.1. Судсаар үргэлжилсэн оношилгоо, эмчилгээ хийх шаардлагатай

5.1.2. Өвчтөний биеийн байдал тогтворгүй байгаа

5.1.3. Мэс засал, ажилбар хийх

5.1.4. Төвийн болон захын судасны хүрц төвөгтэй

5.2. Захын судсанд уян зүү тавихад дараах бэлтгэлийг хангана. Үүнд:

5.2.1. Уян зүүг ажилбарын өрөө эсхүл өвчтөний дэргэд хийнэ.

5.2.2. Ажилбар гүйцэтгэгч нь гуурс байршуулах, засах тохиолдолд 3 удаа амжилтгүй хатгалт хийсний дараа гар сольж хийнэ.

5.2.3. Уян зүү тавихын өмнө ариун бээлий, малгай, амны хаалт, халдваргүйжүүлэх бодис, уян зүү, тариур, хямсаа, чангалуур, шархны тунгалаг лент, цаасан наалт, бөөрөн таваг, хэсэг газрын өвчин намдаагч тос эсвэл цацлага, бал зэргийг бэлдсэн байна.

5.2.4. Өвчтөн эсвэл түүний гэр бүл, асран хамгаалагчаас зөвшөөрөл авч баримтжуулна.

5.3. Захын судсанд уян зүү тавих ажилбарыг дараах дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

5.3.1. Гарыг савандаж угаасаны дараа гарыг спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх уусмалаар халдваргүйжүүлнэ.

5.3.2. Ажилбар гүйцэтгэгч нь ариун бээлий, амны хаалт, малгай өмсөнө.

5.3.3. Уян зүү тавих судсыг сонгохдоо шууны дотор талын судсыг сонгох бөгөөд дараа нь сарвууны арын, тохойны вен байна. Нярай хүүхдэд шагайн, чамархайн болон духны венийг сонгож болно. Ингэхдээ хатгалтын орчим аливаа шарх, халдварын голомт байхаас зайлсхийнэ.

5.3.4. Өвчтөнийг хэвтээ эсхүл суугаа байршилд байршуулна.

5.3.5. Талбайд тэмтрэлт хийж хатгалт хийх газраа тогтооно. Бага насны хүүхдэд өвчин намдаах тос эсхүл цацлага цацаж 1 мин хүлээнэ.

5.3.6. Талбайг 2%-ийн хлоргексидин, 2.5-7.5% повидон-иод, 70%-ийн изопропилын уусмалын аль нэгээр халдваргүйжүүлэлт хийхдээ 30 секундын турш төвөөс зах руу тойргоор арчин улмаар 30 секунд хүлээж хатаана. Талбайг халдваргүйжүүлсэний дараа дахин тэмтрэхээс зайлсхийж үжилгүйжүүлэх техникийг баримтлана.

5.3.7. Чангалуурыг хатгах талбайгаас дээш 5-8 см орчим зайд хэт чанга бус зөвхөн хураагуур судасны урсгалыг хаахаар 3 минутаас хэтрүүлэхгүй тавина.

5.3.8. Уян зүүг байршуулсны тунгалаг наалтаар нааж огноогоо тэмдэглэнэ.

5.3.9. Гуурсыг бөглөрөхөөс сэргийлж 0.9%-ийн физиологийн уусмалаар, түгжинэ.

5.4. Захын судсанд уян зүүн тавьсан өвчтөний шархыг өдөр тутам хянаж дараах явцын арчилгааг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.4.1. Захын судасны байгаа уян зүүг шаардлагатай эсэхийг өдөр бүр үнэлнэ.

5.4.2. Уян зүүг 72 цаг тутамд солих ба боолт нь норсон, цус болсон, хууларсан бол тухай бүрт нь боолтыг солино.

5.4.3. Хуванцар, шалчийдаг, хаалттай дуслын системийг ашиглана.

5.4.4. Уян зүүгээр 10% илүү өтгөн Dextrose, 5% илүү өтгөн уургийн бодис хийхгүй.

5.4.5. Дуслын системээр үргэлжлүүлэн эмчилгээ хийж байгаа тохиолдолд 24 цагийн дотор, пропофол хийсэн бол 6 цагийн дотор системийг сольж дээр нь цагийг тэмдэглэнэ.

5.5. Судсанд байршуулсан гуурсыг авах ажилбарыг дараах дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

5.5.1. Гүйцэтгэгч нь ариун бээлий, амны хаалт, малгай өмсөнө.

5.5.2. Гарын ариун цэврийг сахиж, талбайг үжилгүйжүүлэх техникээр халдваргүйжүүлсэний дараа гуурсыг авч ариун боолт хийнэ.

5.5.3. Өвчтөн халдварын эрсдэлтэй эсхүл ямар нэг халдварын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд гуурсын үзүүрийг хайчлан авч бичил амь судлалын шинжилгээнд илгээнэ.

Зургаа. Судасны гуурстай холбоотой халдвараас сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагын хүлээх үүрэг

6.1. Судсанд гуурс тавих заалт, тавих аргачлал, тавьсан гуурсыг арчлах талаар арга зүйн сургалтыг жил бүр зохион байгуулна.

6.2. Төвийн судсанд гуурсыг байршуулах туршлагатай эмч, захын судсанд гуурсыг байршуулах туршлагатай сувилагч нарыг тус тус сургагч багшаар томилж бусад ажилтныг гардан болон дагалдуулах сургалтыг зохион байгуулна.

6.3. Сурч байгаа ажилтан бие дааж 15-20 удаа алдаагүйгээр судсанд гуурс тавьтал зөвлөх, сургагч багшийн хяналттай судсанд гуурс байршуулна.

6.4. Энэ зааварт заагдсан судсанд гуурс тавихад шаардлагатай хэрэгслүүдээр бүрэн хангана.

6.5. Төвийн судсанд гуурс байршуулах тохиолдол бүрт Төвийн судсанд гуурс тавих шалгуур хуудас (үнэлгээний хуудас №1)-г ашиглаж гарч байгаа алдаа, дутагдлыг тасралтгүй сайжруулах ажлыг зохион байгуулна.

6.6. Судасны гуурстай холбоотой халдварыг тандах хуудсаар (тандалтын хуудас №2) халдварын түвшнийг хянана.

ТӨВИЙН СУДСАНД ГУУРС ТАВИХ ШАЛГУУР ХУУДАС

Эмнэлэг:

Тасаг:

Овог нэр:

Регистрийн №:

Огноо: 20... /... /...

Цаг: / мин

Ажиглагч:

Гуурс тавьсан нөхцөл:

Байршил:

Ажилбарын зорилго:

Яаралтай

Эгэмний дор Гүрээ

Анх удаа

Төлөвлөгөөт

Цавь Бусад

Солих (..... хоногийн дараа)

Авах (..... хоногийн дараа)

АЖИЛБАРЫН ӨМНӨ

1. Өвчтөнөөс зөвшөөрөл авсан: Тийм Үгүй
2. Зөвлөн туслах эмч байгаа: Тийм Үгүй
3. Оператор гараа халдваргүйжүүлсэн:
 - Бөгж, цагаа тайлсан
 - Гараа савандаж угаасан (> 40 секунд)
 - Спиртэн суурьтай уусмал (> 20 секунд)
4. Туслагч гараа халдваргүйжүүлсэн: Тийм Үгүй
6. Оператор эмч: малгай маск ариун нөмрөг ариун бээлий
5. Туслах: малгай маск ариун нөмрөг ариун бээлий
7. Өрөөнд байгаа хүмүүс маск зүүсэн: өвчтөн зөвлөх ажиглагч бусад
8. Өвчтөний байршил: хэвтээ тэгш ууц өндөрлөсөн бусад
9. Талбайн ариутгал: Хлоргексидин 2% Повидон-иод 5-10% Спирт -70%
10. Талбайн ариутгалын хугацаа (>30 секунд, цавь бол 2 мин): Тийм Үгүй
11. Талбайг хатаасан хугацаа (>30 секунд, цавь бол 1 мин): Тийм Үгүй
12. Өвчтөний бүх биеийг ариун хучаасаар хучсан: Тийм Үгүй

АЖИЛБАРЫН ҮЕД

13. Асептик техник баримталсан: Тийм Үгүй
14. Талбайг ариутгасны дараа тэмтрэлт хийгээгүй: Тийм Үгүй
15. Бусад гуурсуудыг түр хаасан: Тийм Үгүй
16. Хатгалтыг амжилттай хийсэн (<3 удаагийн оролдлогоор): Тийм Үгүй
17. Зөвлөх эмч тусалсан: Тийм Үгүй

АЖИЛБАРЫН ДАРАА

18. Боолт хийсэн: Тунгалаг Антибиотик шингээсэн Самбаа
18. Боолт хийсэн огноог тэмдэглэсэн: Тийм Үгүй
19. Гуурсны түгжээ хийсэн: NaCl -0.9% Антикогулант Антибиотик
20. Гуурсны байршлыг рентгенээр баталгажуулсан: Тийм Үгүй
21. Шаардлагүй өөр судасны гуурсыг авсан: Төвийн Захын

Тэмдэглэл:

.....

.....

.....

СУДАСНЫ ГУУРСТАЙ ХОЛБООТОЙ ХАЛДВАРЫГ ТАНДАХ ХУУДАС

Эмнэлэг:
 Үйлчлүүлэгчийн овог нэр:
 Үндсэн онош:
 Судасны гуурсны төрөл:
 Гуурс байршуулсан огноо / цаг.мин:

Тасаг, нэгж:
 Регистрийн №:
 Эмнэлэгт хэвтсэн огноо:
 Байршил:

Сар/өдөр																					
Ээлжийн цаг																					
Судасны гуурсны халдварыг шинж тэмдэгээр тандах хэсэг																					
Хэд дэхь гуурс /солисон тоогоор/																					
Гуурс сольсон шалтгаан																					
Ерөнхий шинж	Халуурна /38C↑/ бусад шалтгаангүй																				
	АД систол буурна <90 мм.муб																				
	Пульс түргэснэ >90 удаа/мин																				
	Шээсний гарц багасна <20 мл/цаг																				
	Арьс зээвхий саарал																				
	Хоолонд дургүй																				
Хэсэг газрын шинж	Хатгасан хэсэг улаан																				
	Хатгасан хэсэгт эмзэг өвчтэй																				
	Хатгасан хэсэгт халуун, үрэвссэн																				
	Тэмтэрэхэд судас гүвдрүүтсэн																				
	Хатгасан хэсэгт буглаатай, идээтэй																				
Авсан арга хэмжээ																					
Цусны ариун чанарын шинжилгээ авсан эсэх, илэрсэн үүсгэгч																					
Гуурсны үзүүрээс нян судлалын шинжилгээ авсан эсэх, илэрсэн үүсгэгч																					
Үрэвслийн шингэн, идээнээс нян судлалын шинжилгээ авсан эсэх, илэрсэн үүсгэгч																					
Авсан арга хэмжээ:																					
Тандалт хийсэн ажилтны нэр, гарын үсэг																					

Тандалтын хуудсыг хөтлөх заавар:

1. Хэвтсэн өдрөөс гарах өдөр хүртэл өдөрт 2 ээлжээр хөтлөнө.
2. Шинж тэмдэг илэрсэн (+), илрээгүй (-), гуурс тависан (Т), солисон (С), авсан (А), орсон-О, гарсан-Г гэж үсгээр товчилж бичнэ.
3. Шинжилгээ авсан (+), аваагүй (-), эмгэг төрөгч илэрсэн үед нэрийг, илрээгүй бол "илрээгүй" гэж бичнэ.
4. Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эмчлэгч эмч, тархвар судлаач эмчид мэдээлнэ.

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 11 сарын 29-ны
өдрийн А/БЗЗ дугаар тушаалын
дөрөвдүгээр хавсралт

ШЭЭЛГҮҮРТЭЙ ХОЛБООТОЙ ШЭЭСНИЙ ЗАМЫН ХАЛДВАР ИЛРҮҮЛЭХ ТАНДАЛТЫН ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шээлгүүртэй холбоотой шинж тэмдэг бүхий шээсний замын халдвар гэдэг нь шээлгүүр тавигдсанаас хойш 48 цагаас хойш нян судлалын шинжилгээнд 2-оос ихгүй төрлийн үүсгэгч $\geq 10^5$ КҮН/мл илрэх, умдагны дээгүүр өвдөх, шээсээ барьж чадахгүй байх, ойр ойрхон шээх, шээхэд өвдөх, ууц нуруу бүсэлхий давсаг орчмоор өвдөх, $65 \leq$ насны хүн $38 \leq$ хэмээс дээш халуурах зэрэг шинж тэмдгээс аль нэг нь илрэхийг хэлнэ.

1.2. Шээлгүүртэй холбоотой халдварын шинж тэмдэггүй шээсний замын халдвар нь шээлгүүр тавигдсанаас хойш 48 цагийн дараа халдварын шинж тэмдэг илрээгүй ч бичил амь судлалын шинжилгээгээр шээсэнд 2-оос ихгүй төрлийн үүсгэгч $\geq 10^5$ КҮН/мл, цусны ариун чанарын шинжилгээнд бичил биетэн илэрсэн байна.

1.3. Үйлчлүүлэгчийн шээс гүйцэт гарахгүй, чихрийн шижин өвчнөөр өвдсөн, өмнө нь антибиотик удаан хугацаагаар хэрэглэсэн, стерIOD болон цитостатик эм хэрэглэж байгаа, шээсний замын урьдал халдвартай, хувийн ариун цэвэр сахилтын байдал муу байх зэрэг нь шээлгүүртэй холбоотой шээсний замын халдварт өртөхөд нөлөөлнө.

1.4. Шаардлагагүй тохиолдолд шээлгүүр тавих, өвчтөнд шээлгүүрийг удаан хугацаанд байрлуулах, шээлгүүрийг ариун бус нөхцөлд бохирдуулан тавих, нэг удаагийн багаж хэрэгслийг давтан хэрэглэх, шээлгүүрийн бэхэлгээг буруу хийх нь шээсний замын халдварт өртөх эрсдэлт хүчин зүйл болдог.

Хоёр. Тандалт хийх аргачлал

2.1. 48 цагаас дээш хугацаанд шээсний сүвээр давсанд тавьсан уут бүхий шээлгүүр (фоликатетр) тавигдсан үйлчлүүлэгчид шээлгүүртэй холбоотой шээсний замын халдварын тандалтыг бүдүүвч 1-д харуулсан алгоритмийн дагуу хийнэ.

2.2. Шулуун, бөмбөлөг хэлбэрийн оролт гаралттай шээлгүүр, нефростомийн гуурс, стомийн гуурс, цистомийн гуурс тавигдсан тохиолдолд шээлгүүртэй холбоотой шээсний замын халдвар илрүүлэх тандалтыг хийхгүй.


2.3. Шээлгүүр тавигдсан үйлчлүүлэгчид "Шээлгүүртэй холбоотой шээсний замын халдварыг шинж тэмдгээр тандах хуудас"-аар тандалтыг өдөр бүр хийнэ.

2.4. Халдварын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд шээсийг бичил амь судлалын шинжилгээнд авахдаа хуучин шээлгүүрийг шинээр сольсоны дараа шинэ шээлгүүрээр гарсан шээсний дунд хэсгээс ариун саванд авна.

2.5. Бичил амь судлалын лабораторид шээсийг илгээхдээ шинжилгээний дагалдах хуудсанд “Сэжигтэй тохиолдол” гэж тэмдэглэн илгээнэ.

2.6. Шээлгүүртэй холбоотой шээсний замын халдварын тохиолдол илэрсэн үед холбогдох зааврын дагуу мэдээлж хариу арга хэмжээг авна.

Шээсний замын халдвар илрүүлэх бүдүүвч 1



Дөрөв. Шээлгүүртэй холбоотой шээсний замын халдвараас сэргийлэх арга хэмжээ

- 4.1. Шаардлагагүй тохиолдолд шээлгүүр тавихаас зайлсхийнэ.
- 4.2. Шээлгүүрийг аль болох богино хугацаанд байрлуулна.
- 4.3. Сургагдсан эмнэлгийн мэргэжилтэн шээлгүүр тавих ажилбарыг гүйцэтгэнэ.
- 4.4. Шээлгүүрийг ариун багаж, хэрэгслээр үжилгүйжүүлэх техникийг баримтлан тавина.

4.5. Шээлгүүр тавих болон авах, арчилгааны үед гарын ариун цэвэр сахих, байнгын сэргийлэлтийг мөрдөн ажиллана.

4.6. Үйлчлүүлэгч хөдлөхөд шээлгүүр дахь шээс давсаг руу буцаж урсахаас сэргийлж гуурсыг хаах, хаалттай шээлгүүрийг сонгоно. Том диаметртэй шээлгүүр нь шээсний сүвний салстад даралт үүсгэж гэмтээдэг, цус зогсонгишлоос хэсэг газар үхэждэг тул аль болох жижиг диаметртэй шээлгүүрийг сонгож хэрэглэнэ. Мөн бактерийн эсрэг үйлчилгээтэй шээлгүүрийг (мөнгөний хольцтой, бактерийн эсрэг үйлчилгээтэй материалаар хийгдсэн гэх мэт) хэрэглэж болно.

4.7. Шээсний нян судлалын шинжилгээгээр олон эмэнд тэсвэртэй бичил биетэн илэрсэн үед үйлчлүүлэгчийг тусгаарлаж нэмэлт сэргийлэлтийн арга хэмжээг авна.

Шээлгүүртэй холбоотой халдварын тархвар судалгааны хуудас

Овог, нэр	Регистерийн дугаар:
Хүйс: Эм Эр	Төрсөн он сар өдөр:
Эмнэлэгт хэвтсэн он сар өдөр:	Халдварын тохиолдлыг бүртгэсэн он сар өдөр:
Шээлгүүртэй байсан хоног	
Эрсдэлт хүчин зүйл:	
Хэрвээ Хүүхдийн эрчимт эмчилгээний тасаг бол хүүхдийн жин, өндөр:	
Илрэх шинж тэмдэг: <input type="checkbox"/> Халууралт <input type="checkbox"/> Шээсээ барьж чадахгүй болох <input type="checkbox"/> Дизури <input type="checkbox"/> Шээхэд хорсох <input type="checkbox"/> Умдагны дээгүүр өвдөх <input type="checkbox"/> Буглаа <input type="checkbox"/> Эпидидимит <input type="checkbox"/> Простат <input type="checkbox"/> Ууц, нуруу, бүсэлхий, давсаг орчмоор өвдөнө <input type="checkbox"/> Ойр, ойрхон шээс хүрнэ <input type="checkbox"/> Шээх үед шээсний сүвээр хорсож өвдөнө. 1 хүртэлх насны хүүхдэд илрэх шинж тэмдэг: <input type="checkbox"/> Халуурах <input type="checkbox"/> Гипотерми <input type="checkbox"/> Апноэ <input type="checkbox"/> Брадикарди <input type="checkbox"/> Эмгэг нойрсолт <input type="checkbox"/> Бөөлжилт	Лабораторийн шинжилгээний үзүүлэлтүүд: <input type="checkbox"/> Нян судлалын шинжилгээнд 2 хүртэл төрлийн нян $\geq 10^5$ КҮН/мл хүртэл ургалттай байх <input type="checkbox"/> Шээсний ерөнхий шинжилгээнд лейкоцит эстераза, нитрит эерэг байх <input type="checkbox"/> Пиури ≥ 10 WBC/mm ³ <input type="checkbox"/> Нейтропени ≤ 500 WBC cells/mm ³ <input type="checkbox"/> Нян судлалын шинжилгээнд 1 төрлийн нян $\geq 10^3$ КҮН/мл хүртэл ургалттай байх, 2 төрлийн нян $< 10^5$ КҮН/мл хүртэл ургалттай байх <input type="checkbox"/> Грамын будгаар будаж харахад нян харагдах <input type="checkbox"/> Өсгөвөр ургалттай байх <input type="checkbox"/> Цусанд нян ургах
<input type="checkbox"/> Шээлгүүртэй холбоотой шинж тэмдэгтэй шээсний замын халдвар <input type="checkbox"/> Шээлгүүртэй холбоотой шинж тэмдэггүй шээсний замын халдвар	
Хоёрдогчоор цусан халдварт өртсөн эсэх <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
Нас барсан эсэх <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	

Шээлгүүртэй үйлчлүүлэгчдийн дунд бөөр, шээсний замын халдварыг тандах хуудас

Сар өдөр	Үйлчлүүлэгчдийн овог, нэр	Эмчлүүлэгчийн түүхийн дугаар	Шээлгүүр тавих үеийн халдварын шинж			Шээлгүүртэй байсан хугацаа (хоног, цагаар)	Эмнэл зүйн шинж тэмдэг						Шээсний шинжилгээнд нянгийн тоо 10^5 ихсэх	Шээсний шинжилгээнд олон төрлийн нян ургах	Шээсэнд цагаан эсийн тоо олшрох	Илэрсэн үүсгэгч	Тандалт хийсэн хүний нэр
			Шээсний сүв улайж үлэвссэн	Цустай шээсэн	Бусад		Халуурах (Бусад шалтгаангүй)	Дизурия	Идээтэй шээх	Умдаг дээр өвдөх	Давсаг шархирах, өвдөх	Шээсний сүв хорсох, улайх					

Тайлбар:

1. Тандалтын хуудсыг бүх шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагад хөтлөгдөнө.
2. Тандалт хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн халдварын шинж тэмдэг илэрч буй тохиолдолд +, илрээгүй бол – тэмдгээр тус тус тэмдэглэнэ.
3. Илэрсэн тохиолдолд эмнэлгийн дарга, тасгийн эрхлэгч, тархвар судлаач эмчид мэдээлнэ.

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 11 сарын 29-ны
өдрийн А/539 дугаар тушаалын
тавдугаар хавсралт

ЗОХИОМОЛ АМЬСГАЛЫН АППАРАТТАЙ ХОЛБООТОЙ УУШГИНЫ ХАТГАА ИЛРҮҮЛЭХ ТАНДАЛТЫН ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушгины хатгаа (VAP): Зохиомол амьсгалын аппаратаар дэмжигдсэнээс хойш 48 цаг болж байгаа үйлчлүүлэгчид уушгины хатгаа илрэхийг хэлнэ.

1.2. Уушгины хатгааны шинж илэрсэн үйлчлүүлэгч нь өөр эмнэлгээс шилжин ирж буй тохиолдолд өмнөх эмнэлэгт зохиомол амьсгалын аппаратаар дэмжигдэж байсан өдрөөс эхлэн тооцно.

1.3. Уушгины хатгаа өвчнийг бодит үзлэг, эмнэлзүйн болон лабораторийн шалгуурыг үндэслэн тодорхойлдог.

Хүснэгт 1

	Шалгуур
Цээжний рентген зураг	Доорх үзүүлэлтээс аль нэг нь илрэх Уушгинд сүүдэржилт, нэвчдэс эсвэл эдийн нягтрал үүсээд 72 цаг эсвэл түүнээс өмнө үүссэн байх Уушгинд хөндий үүссэн байх
Системийн шинж тэмдгүүд	Доорх үзүүлэлтээс аль нэг нь илрэх Сүүлийн 24 цагийн дотор биеийн халуун 38 хэмээс ихэссэн Сүүлийн 24 цагийн дотор цагаан эс 4000-аас бага, эсвэл 12000-аас их байх (WBC/mm ³)
Уушгины талаас илрэх өөрчлөлт	Бүгд илрэх 48 цагийн турш агааржуулалтын FiO ₂ > 15 мм МУБ-аас тогтмол ихсэх ЭСВЭЛ 48 цагийн турш агааржуулалтын PEEP ≥ 5 см H ₂ O ₂ -аар тогтмол ихсэх ЭСВЭЛ FiO ₂ > 10 мм МУБ огцом ихсэх, 48 цагийн турш PEEP > 2.5 см H ₂ O ₂ –аар ихсэх Уушгины шүүрлийн сорьцонд нян илрэх мөн сүүлийн 72 цагийн турш ≥ 25 нейтрофил илрэх


Хоёр. Тандалт хийх аргачлал

2.1. Халдварын сэжигтэй тохиолдлыг илрүүлэх тандалтыг “Зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушгины хатгааг тандах бүдүүвч”-ийн дагуу бодит үзлэг,

эмнэл зүйн болон лабораторийн шалгуурыг үндэслэн зохиомол амьсгалын аппараттаар дэмжигдэж байгаа бүх үйлчлүүлэгчдэд өдөр бүр эмчлэгч эмч хийнэ.

2.2.Тандалтыг “Халдварыг шинж тэмдгээр тандах хуудас”-ын дагуу тогтмол хөтөлнө.

Зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушгины хатгааг тандах бүдүүвч



Гурав. Эрсдэлт хүчин зүйл, халдвараас сэргийлэх

3.1 Үйлчлүүлэгчтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлд 70-аас дээш настай байх, уушгины архаг өвчин ба эсвэл бусад хавсарсан өвчин, ялангуяа чихрийн шижин, ухаан санаа алдагдах, тархины судасны цочмог эмгэг, олон эрхтний дутагдал, амны хөндийн эрүүл ахуй муу байх, өмнө нь антибиотик, гормон, эсэд хортой эм хэрэглэдэг байдал хамаарна.

3.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлд цээж, хэвлийн мэс засал, зохиомол амьсгалын аппарат, интубаци тавих, хамрын гуурсаар хооллох, биеийн байрлал, хамар залгиурын бичил биетэн колонизаци болох, нэг удаагийн багаж хэрэгслийг давтан хэрэглэх, антибиотикийн зохисгүй хэрэглээ, халдварын сэргийлэлт хяналт, гарын ариун цэвэр, эрүүл мэндийн ажилтны мэдлэг дутмаг байх нь нөлөөлнө.

3.3. Цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавьсаны дараах зохиомол амьсгалын аппаратын шалтгаант уушгины хатгаа үүсэх хугацаа нь дунджаар 3.3 өдөр байдаг тул зохиомол амьсгалын аппаратанд холбосон эхний 5 өдөр хамгийн их эрсдэлтэй.

3.4. Зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушгины хатгаа нь эрт үедээ (цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавьснаас хойш 4 хоногийн дотор үүсдэг) *Стрептококк пневмония* (стрептококкын бусад зүйл), хаемофилус инфулиенза, метицилинд мэдрэг *Стафилококк аурес* (ММСА), антибиотикт мэдрэг гэдэсний грам сөрөг бацилл, *эшериха коли*, *клебсиелла пневтония*, *Энтеробактерийн* зүйл, *протеус* зүйл, *серрация маркесценс* зэрэг үүсгэгчдээр үүсгэгддэг.

3.5. Зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушгины хатгаа нь хожуу үед (цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавьсаны дараа 4 дэхь өдрөөс хойш) олон эмэнд тэсвэртэй бичил биетэнээс үүдэлтэй. Тухайлбал Метицилинд тэсвэртэй стафилококк аурес (МТСА), Аценитобактер, псевдомонас аерогиноза, өргөн хүрээний бета-лактамаза үүсгэгч гэх мэт.

3.6. Үйлчлүүлэгчийг зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушгины хатгаанаас сэргийлэхийн тулд дараахь зарчмыг баримтална. Үүнд:

3.6.1. Үйлчлүүлэгчийн цээжин биеийг 30-45 хэмийн налуу өндөрлөж, 2 цаг тутамд 40 хэмийн механик эргүүлэлт хийнэ.

3.6.2. Аппараттай байх хугацааг аль болох багасгаж өөрөө амьсгалах боломжтой бол аппарат салгана.

3.6.3. Өдөр тутам амны хөндийн арчилгааг хийж, хэлэн доорх шүүрлийг байнга гадагшлуулж соруулах шаардлагатай.

3.6.4. Хооллох гуурсыг нугалуураас хойш хэсэгт байрлуулбал халдвар үүсэх, ходоодны агууламж амьсгалын замд сорогдохоос сэргийлнэ.

Зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушгины хатгааны тархвар судалгааны хуудас

Овог, нэр	Регистерийн дугаар:	
Хүйс: Эм Эр	Төрсөн он сар өдөр:	
Эмнэлэгт хэвтсэн он сар өдөр:	Халдварын тохиолдлыг бүртгэсэн он сар өдөр:	
Халдварын төрөл: Уушигны хатгаа	Халдвар авсан огноо: он сар өдөр	
Амьсгалын аппаратаар дэмжигдсэний дараа уушигны хатгаа авсан <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	Амьсгалын аппаратаар дэмжигдсэн огноо: он сар өдөр	
:	Өвчний ангилалын код (ICD-10):	
Эмнэлэгт хэвтсэн огноо: он сар өдөр	Тасгийн нэр:	
Эрсдэлт хүчин зүйл		
Амьсгалын аппарат хэрэглэсэн: <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй Амьсгалын аппарат тавьсан тасаг, нэгжийн нэр: Амьсгалын аппарат тавигдсан нийт өдөр: Хэрвээ эрчимт эмчилгээний тасаг бол жин: өндөр:		
Халдварын шинж тэмдгийн дэлгэрэнгүй мэдээлэл		
Дархлал дарангуйлагдсан: <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй <u>Уушигны рентген зургийн мэдээлэл:</u> <input type="checkbox"/> Уушгинд шинээр голомт үүссэн ба голомт нэмэгдсэн <input type="checkbox"/> Эдийн нягтрал үүссэн <input type="checkbox"/> Хөндий үүссэн <input type="checkbox"/> Уушигний хатгалгаа нь 1 ба түүнээс доош насны хүүхэд бол		
Илрэх шинж тэмдэг	Лабораторийн шинжилгээний үзүүлэлт	
<input type="checkbox"/> Халууралт <input type="checkbox"/> Цагаан эсийн тоо буурах эсвэл Цагаан эсийн тоо ихссэн <input type="checkbox"/> Насанд хүрэгчид ба 70 түүнээс дээш насныхан <input type="checkbox"/> Идээт цэртэй <input type="checkbox"/> Ханиалга нэмэгдэх, <input type="checkbox"/> Амьсгал авалт удаахрах, амьсгал олшрох <input type="checkbox"/> Хэржигнэх эсвэл бронхийн чимээ сонсогдох <input type="checkbox"/> Амьсгалын дутагдал гүнзгийрэх <input type="checkbox"/> Цустай ханиалгах <input type="checkbox"/> Цээжээр өвдөх <input type="checkbox"/> Ханиалгах <input type="checkbox"/> Халуун тогтвортой бус <input type="checkbox"/> Гипотерми <input type="checkbox"/> Апноэ <input type="checkbox"/> Брадикарди <input type="checkbox"/> Тахикарди	<input type="checkbox"/> Цусанд нян илрэх <input type="checkbox"/> Гялтангийн шингэнд нян илрэх <input type="checkbox"/> Амьсгалын доод замын сорьцонд нян илрэх <input type="checkbox"/> Гуурсан хоолойн шинжлэгдэхүүнд нян илрэх <input type="checkbox"/> Уушигны эдээс нян илрэх <input type="checkbox"/> Гистологи шинжилгээгээр буглаа үүсэх, уушигны паренхимд мөөгөнцөрийн төрөл илрэх. <input type="checkbox"/> Цус болон цэрний шинжлэгдэхүүнд <i>Candida</i> илрэх. <input type="checkbox"/> Аль нэг шинжлэгдэхүүнд <i>Bordetella</i> , <i>Legionella</i> эсвэл Хламид илрэх <input type="checkbox"/> Шээсэнд <i>L pneumophila</i> нэгдүгээр хэв шинжийн эсрэг бие илрэх <input type="checkbox"/> Амьсгалын замын шүүрэл, уушигны эдээс вирус, <i>Bordetella</i> , Хламид, <i>Mycoplasma</i> , <i>Legionella</i> илрэх <input type="checkbox"/> <i>L pneumophila</i> эсрэг биеийн титр 4 дахин ихсэх <input type="checkbox"/> Гуурсан хоолойн шинжлэгдэхүүнд иөөгөнцөр илрэх	
Хоёрдогчоор цусан халдварт өртсөн эсэх <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй		
Нас барсан эсэх <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй		
Амьсгалын аппараттай холбоотой уушигны хатгалгаа нь нас баралтанд хүргэсэн эсэх <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй		
Нян судлалын шинжилгээнд эмгэг төрөгч нян илэрсэн эсэх <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй		

Амьсгалын аппараттай үйлчлүүлэгчдийн дунд уушгины хатгалгааг тандах хуудас

Сар өдөр	Үйлчлүүлэгчдийн овог, нэр	Эмчлүүлэгчийн түүхийн дугаар	Амьсгалын аппараттай хэд дэх хоног	Эмнэл зүйн шинж тэмдэг							Илэрсэн үүсгэгч	Тандалт хийсэн хүний нэр	
				38 хэмээс дээш халуурах	Цээж хэржигнүүртэй	Идээрхэг цэр гарсан эсэх	Ханиалгах	Амьсгалын тоо олшрох	Цээж хонхолзох (хүүхдэд)	Рентгенд өөрчлөлттэй			Цэрний шинжилгээнд нян ургах

Тайлбар:

1. Тандалтын хуудсыг бүх шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагад хөтлөгдөнө.
2. Тандалт хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн халдварын шинж тэмдэг илэрч буй тохиолдолд +, илрээгүй бол – тэмдгээр тус тус тэмдэглэнэ.
3. Илэрсэн тохиолдолд эмнэлгийн дарга, тасгийн эрхлэгч, тархвар судлаач эмчид мэдээлнэ.

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 11 сарын 29 -ны
өдрийн 1539 дугаар тушаалын
зургаадугаар хавсралт

ЭРСДЭЛТЭЙ БҮЛГИЙН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХАЛДВАР ИЛРҮҮЛЭХ ТАНДАЛТЫН ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. ЭТҮХХ авах эрсдэл өндөртэй үйлчлүүлэгч эмнэлгийн тусламж үйчилгээний явцад халдварт өртөж буй эсэхийг энэхүү зааврын дагуу тандана.

1.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварт өртөх эрсдэл өндөртэй бүлэгт дараах үйлчлүүлэгчийг хамруулна.

1.2.1. Эрхтэн шилжүүлэн суулгасан, дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэж байгаа үйлчлүүлэгч;

1.2.2. Диализ эмчилгээнд тогтмол орж байгаа үйлчлүүлэгч;

1.2.3. Төрсөн эх, нярай;

1.2.4. Цусны хавдартай хүүхэд

1.3. Эрсдэл өндөртэй үйлчлүүлэгч судасны гуурстай, шээлгүүр, зохиомол амьсгалын аппараттай, мэс засалд орсон бол тус бүрийн зааврын дагуу тандалтад өдөр бүр хамрагдана.

1.4. Дээрх ажилбарт ороогүй, биед гадны хэрэгсэлгүй бол өдөр бүр тандалтад хамрагдах шаардлагагүй.

Хоёр. Эх, нярайд ЭТҮХХ –ыг тандах, халдвараас сэргийлэх

2.1. Амаржих газар, төрөх тасагт нярайд асаргаа, сувилгаа, үзлэг хийж байгаа эмнэлгийн мэргэжилтэн хүй, нүдний салст үрэвсэх, арьсан дээрх тууралт, бусад ямар нэгэн халдварын шинж байгаа эсэхийг үзэж нярайн түүхэнд тэмдэглэнэ.

2.2. Халдварын сэжигтэй тохиолдол илэрмэгц тархвар судлаач, тасгийн эрхлэгч, халдварын сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэнд нэн даруй мэдээлнэ.

2.3. Амаржих газар, төрөх тасагт ЭТҮХХ-ын тохиолдол болон дэгдэлт гарсан үед бүх эх, нярайд тухайн халдварын шинж тэмдэг байгаа эсэхийг илрүүлэх тандалт хийнэ.

2.4. Эх нярайд халдвар дамжуулж болох халдварын эрсдэлтэй үед энэхүү хавсралтын 2.14-д заасны дагуу арга хэмжээ авна. Эх үтрээний ялгадас их, төрөх үед бэлгийн замын халдвартай, халдварт өвчний сэжиг бүхий, халуурах зэрэг тохиолдолд эх барихын удирдамжийн дагуу нярайг халдвараас сэргийлэх арга хэмжээ авна.

2.5. Бусад эх, нярайд халдвар дамжихаас сэргийлж тусгаарлах арга хэмжээ авч 1 өрөөнд хамт байсан, халдвар авсан байх боломжтой эх, нярайг халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулна.

2.6. Амаржих газар, төрөх тасгаас гарснаас хойш 28 хоног дотор ямар нэгэн шалтгаанаар эмнэлэгт эргэж хэвтсэн тохиолдол бүрийг тархвар судлаач эмч бүртгэж, тархвар судалгаа хийнэ.

2.7. Мэс заслаар төрсөн эхийг мэс заслын дараах шархны халдвар илрүүлэх тандалтад өдөр бүр хамруулж, халдварын шинж тэмдэг тандах тандалтын хуудсыг хөтөлнө.

2.8. Төрөх замаар болон мэс заслаар төрсөн эх амаржсаны дараа 30 хоног дотор эргэж хэвтсэн бол тархвар судлаач эмчид мэдээлнэ. Тархвар судлаач эмч халдварын шалтгаан байгаа эсэхийг тодруулан тархвар судалгааг хийнэ.

2.9. Амаржих газар, төрөх тасгаас гарсны дараа харьяа өрх, сумын эмч, сувилагч эх, нярайд халдварын шинж тэмдэг байгаа эсэхийг тандана.

2.9.1. Төрсний дараа 1 сарын дотор эргэлтээр очих үедээ;

2.9.2. Тухайн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх үед тандалт хийнэ.

2.10. ЭТҮХХ-ын сэжигтэй бол бүртгэж ЭМГ, ЭМТ-д мэдээлнэ.

2.11. Эх, нярайд зонхилон тохиолддог ЭТҮХХ-ын тохиолдлыг дараах шалгуураар тогтооно.

Эх, нярайд зонхилон тохиолддог ЭТҮХХ-ын тохиолдлын тодорхойлолт, лабораторийн шалгуур

Халдварын ангилал	Тохиолдлын тодорхойлолт	Лабораторийн шалгуур
Цусны халдварууд (үжил)	<p>Дараах шинж тэмдгээс аль нэг шинж илэрсэн.</p> <ul style="list-style-type: none"> Шалтгаангүйгээр 38 хэм ба түүнээс дээш халуурах. Даралт унана (систолийн даралт <90 мм рт.ст.) Шээсний гарц хэмжээ багасна (>20 мл/цаг). Судасны цохилт түргэснэ(>90 удаа/мин). Арьсны өнгө өөрчлөгдөж, зэвхий саарал болно. <p>Хүүхдэд дараах шинжүүдээс аль нэг нь илрэх:</p> <ul style="list-style-type: none"> Шалтгаангүйгээр 38 хэм ба түүнээс дээш халуурах, эсвэл 37 хэмээс бууна. Апноэ эсвэл брадикарди илэрнэ. Арьс эрээнтэж, сааралтана. Хоол, хөхөндөө дургүйцнэ Нойрмог, унтаа болно. 	<p>Тодорхой байрлалтай халдвар илрээгүй байхад:</p> <p>Цусанд эмгэгтөрөгч нян ургана.</p> <p>Эсвэл</p> <p>Цусанд 2 удаагийн нян судлалын шинжилгээгээр арьсны хэвийн бичил биетэн ургах</p> <p>Эмч үжлийн заалтаар нянгийн эсрэг эмчилгээ хийсний дараа, сорьц буруу авсан, шинжилгээний алдаа зэргээс шинжилгээнд нян илрэхгүй байж болно.</p>

Халдварын ангилал	Тохиолдлын тодорхойлолт	Лабораторийн шалгуур
Төв мэдрэлийн тогтолцооны халдварууд	<p>Тархины буглаа/ энцефалит:</p> <p>Нянгийн эсрэг эмчилгээ хийгдэж байхад дараах шинж тэмдгүүдээс 2-оос доошгүй шинж илэрнэ.</p> <ul style="list-style-type: none"> • 38 хэм ба түүнээс дээш халуурах. • Толгой өвдөнө. • Толгой эргэнэ. • Төв мэдрэлийн гэмтлийн голомтот өөрчлөлтийн шинжүүд илэрнэ. • Ухаан санаа балартана. <p>Менингит: Дараах шинж тэмдгүүд илэрнэ.</p> <ul style="list-style-type: none"> • 38 хэм ба түүнээс дээш халуурах. • Толгой өвдөнө. • Бөөлжинө. • Хүзүү хөшингө болно. • Мэнэнгийн шинжүүд илэрнэ. • Цочромтгой болно. <p>Голомтот өөрчлөлтийн шинжүүд илэрнэ</p>	<p>Тархины буглаа/ энцефалитийн үед:</p> <ul style="list-style-type: none"> • Тархины эд болон тархины хатуу бүрхэвчийн эдийн сорьцод нян ургана. • Цус, шээсэнд эсрэгтөрөгч эерэг байна. • Ийлдсэнд эмгэгтөрүүлэгчийн IgM, IgG эсрэг биеийн титр өндөр байх <p>Менингитийн үед: Тархи нугасны шингэний сорьцонд нян ургана.</p> <ul style="list-style-type: none"> • Тархи нугасны шингэнд уураг болон цагаан эсийн тоо олшрох ба сахарын хэмжээ багасна. • Цусанд нян ургана. • Тархи нугасны шингэнийг Грамаар будаж микроскопоор харахад эмгэгтөрөгч нян илэрнэ. <p>Ийлдсэнд эмгэгтөрүүлэгчийн IgM, IgG эсрэг биеийн титр өндөр байх</p>
Яс болон үений халдварууд	<p>1. Ясны идээт үрэвсэл: Дараах шинж тэмдгүүдээс илэрнэ.</p> <ul style="list-style-type: none"> ▪ 38 хэм ба түүнээс дээш халуурах. ▪ Хэсэг газрын үрэвслийн шинж тэмдэг илрэх (өвдөлт, улайлт, хавагнах, халуу оргих г.м) ▪ Халдварын голомтоос шүүрэл гарна. ▪ Хагалгааны үед болон гистологи шинжилгээнд идээт үрэвслийн шинж илэрнэ. <p>2. Үе болон үений хүүдийн халдвар: Шалтгаангүйгээр дараах шинж тэмдгүүд илэрнэ.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Үеэр өвдөнө ▪ Үе хавагнана, халуу оргино. ▪ Үений хөдөлгөөн хязгаарлагдана. ▪ Хагалгааны үед халдварын шинж илэрнэ. 	<p>1. Ясны идээт үрэвслийн үед дараах нөхцлийн аль нэг нь байна.</p> <ul style="list-style-type: none"> • Ясны эдийн сорьцод нян ургана. • Цусанд нян ургана. • Рентген шинжилгээгээр идээт үрэвслийн өөрчлөлт илэрнэ. <p>2. Үе болон үений хүүдийн халдварын үед:</p> <ul style="list-style-type: none"> • Үений шингэн болон үений эдийн шинжилгээнд нян ургана. • Рентген шинжилгээнд халдварын шинж илэрнэ. <p>Биохимийн шинжилгээнд хэрх өвчний шинж тэмдэг илрэхгүй</p>

Халдварын ангилал	Тохиолдлын тодорхойлолт	Лабораторийн шалгуур
<p>Амьсгалын замын халдварууд</p>	<p>Уушгины хатгалгаа: Дараах шинж тэмдгүүдээс аль нэг нь заавал илэрнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Хэржигнүүр сонсогдох эсвэл тогшилтын авиа дүлий болно. • Идээт цэртэй ханиалгах ба цэрний шинж төрх өөрчлөгдөнө. • Амьсгалын тоо олшрох. <p>Нэг хүртэлх насны хүүхдэд энэ үед дараах шинж тэмдэгээс 2-с доошгүй илэрнэ.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Апноэ ▪ Амьсгалын тоо олшрох ▪ Брадикарди ▪ Хэржигнүүр сонсогдоно. ▪ Ханиалгана. ▪ Идээтэй цэр ялгарах ба цэрний шинж төрх өөрчлөгдөнө. ▪ Цээж хонхолзоно. <p>Амьсгалын дээд замын халдваруудад фарингит, ларингит, эпиглотит багтана.</p> <ul style="list-style-type: none"> • 38°С ба түүнээс дээш халуурна. • Залгиурын арын хана улайна. • Ханиалгана. • Хоолой сөөнгөтнө. • Гүйлсэн буйлчирхай үрэвсэнэ. • Хоолойноос идээ гарна. 	<p>А.Уушгины хатгалгааны үед:</p> <ul style="list-style-type: none"> • Цусанд бичил биетэн ургах • Мөгөөрсөн хоолойн наацад бичил биетэн илрэх • Цэрэнд нян ургах • Гуурсан хоолойн шүүрэлд вирус ялгах эсвэл вирусийн эсрэг антиген илрэх • Үүсгэгчийн эсрэгбие IgM, IgG-ийн титр өндөр байх • Цээжний рентгенд: Нэвчдэст өөрчлөлт, сөнөрөл, цээжний гялтангийн наалдалт <p>Амьсгалын дээд замын халдваруудын үед:</p> <ul style="list-style-type: none"> • Гэмтсэн хэсгээс авсан сорьцонд нян ургах • Цус ба гуурсан хоолойн шүүрэлд эсрэгтөрөгч эерэг байх • Ийлдсэнд үүсгэгчийн эсрэг бие IgM, IgG-ийн титр өндөр байх • Гистологийн шинжилгээгээр батлагдсан байх
<p>Хоол боловсруулах эрхтэний тогтолцооны халдварууд</p>	<p>Гастроэнтерит:</p> <ul style="list-style-type: none"> • Суулгана (12 цагаас дээш). • Бөөлжинө. • 38 хэм ба түүнээс дээш халуурна. • Хэвлийгээр өвдөнө. • Толгой өвдөнө. <p>Нярайн гэдэсний үхжилт халдвар: Дараах шинжүүдээс 2-оос доошгүй шинж илэрнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Бөөлжинө. • Гэдэс дүүрнэ. • Гулгина. 	<p>Гастроэнтеритийн үед:</p> <ul style="list-style-type: none"> • Өтгөн ба шулуун гэдэсний арчдсанд гэдэсний нян, эмгэгтөрөгч нян ургах • Цусанд гэдэсний нянгийн эсрэгтөрөгч ба эсрэгбие илрэх • Эмгэгтөрүүлэгчийн IgM, IgG эсрэг биеийн титр өндөр байх <p>Нярайн гэдэсний үхжилт халдварын үед:</p> <p>Рентгенд дараах шинж тэмдгээс аль нэг нь илэрнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Хэвлийд хий хуралдах • Гэдэсний гогцоонд хий саатах • Нарийн гэдэсэнд хөдөлгөөнгүй гогцоо үүснэ.

Халдварын ангилал	Тохиолдлын тодорхойлолт	Лабораторийн шалгуур
Арьс, халимны халдвар	<p>1. Арьсны халдварууд: Дараах шинж тэмдгээс аль нэг нь илэрнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Идээт • Цэврүүт • Идээт цэврүүнцэрт • Шүүдэст тууралт • Хатиг гарах ба үүнээс гадна дараах шинж тэмдэг илэрнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Хэсэг газрын өвдөлт, эмзэглэл • Хавагнах, улайх, халуу оргино. <p>2. Зөөлөн эдийн халдварууд: Үхжилт фасцилит, идээт үхжил, үхжилт целлюлит, халдварт миозит, лимфаденит, лимфангит багтана.</p> <ul style="list-style-type: none"> • Халдвартай хэсгээс идээ гарна. • Мэс ажилбарын явцад идээт буглаа эсвэл халдварын шинж илэрнэ. • Хэсэг газрын үрэвслийн шинжүүд (өвдөлт, эмзэглэл, улайлт, хаван, халуу оргих г.м) илэрнэ. <p>3. Нярайн хүйн үрэвсэл: Төрснөөс хойш 28 хүртэл хоногт тооцно.</p> <p>Дараах шинж тэмдэг илэрнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Хүйс улайх • Хүйнээс шүүрэл, идээ гарна. <p>3. Нярайн цэврүүт тууралт:</p> <ul style="list-style-type: none"> • Арьсан дээр цэврүүт тууралт гарна. • Арьс улайж, хавагнана. 	<p>1. Арьсны халдварын үед:</p> <ul style="list-style-type: none"> • Халдвартай хэсэг газраас ялгарч буй шүүрэлд нян ургана. • Цусанд нян ургана. • Ийлдсэнд эмгэгтөрүүлэгчийн IgM, IgG эсрэг биеийн титр өндөр байх <p>2. Зөөлөн эдийн халдварын үед:</p> <ul style="list-style-type: none"> • Халдвартай хэсгийн эд болон ялгарч буй шүүрлийн сорьцонд нян ургана. • Цусны сорьцонд нян ургана. • Микроскопийн шинжилгээгээр олон бөөмт аварга эсүүд харагдана. • Ийлдсэнд эмгэгтөрүүлэгчийн IgM, IgG эсрэг биеийн титр өндөр байх <p>3. Нярайн хүйн үрэвслийн үед:</p> <ul style="list-style-type: none"> • Хүйн арчдсанд нян ургана. • Цусанд нян ургана. Шинжилгээ хийгдээгүй буюу нян илрэхгүй байж болно.
Нүдний халдвар	<p>1. Нүдний конъюнктивит</p> <p>Идээрхэг нуух гарна.</p> <ul style="list-style-type: none"> • Нүд улайна. • Нүд өвдөнө. • Зовхи хавагнана. 	<p>А. Конъюнктивитийн үед:</p> <ul style="list-style-type: none"> • Нуухны арчдсанд нян илэрнэ. • Нуухны арчдсыг грамаар будаж харахад эмгэгтөрөгч нян ба цагаан эс харагдана.

Халдварын ангилал	Тохиолдлын тодорхойлолт	Лабораторийн шалгуур
<p style="text-align: center;">Нөхөн үржихүйн эрхтэн, тогтолцооны халдварууд</p>	<p>Нөхөн үржихүйн эрхтэн, тогтолцооны халдваруудад эндометрит, эпизиотомийн дараах халдвар, үтрээний арын хүнхрээний үрэвсэл, нөхөн үржихүйн эрхтний бусад халдварууд багтана.</p> <p>1. Эндометрит:</p> <ul style="list-style-type: none"> • Умайгаас идээт шүүрэл ялгарна. • 38 хэм ба түүнээс дээш халуурах. • Хэвлийгээр өвдөнө. • Умай эмзэглэлтэй байна. <p>2. Эпизиотомийн дараах халдвар: Дараах шинж тэмдгийн аль нэг илэрнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Зүслэг хийсэн газраас идээ гарна. • Зүслэг хийсэн хэсэг газар идээт буглаа үүснэ. • Шарх задарна. <p>3. Үтрээний арын хүнхрээний үрэвсэл: Дараах шинж тэмдгийн аль нэг илэрнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Үтрээнээс идээ гарах • Арын хүнхрээнд идээт буглаа үүснэ. • Арын хүнхрээ цүлхийж, идээт ялгадас гарна. <p>4. Нөхөн үржихүйн эрхтний бусад халдваруудад өндгөвч, түрүү булчирхайн үрэвсэл ба эндометрит, арын хүнхрээний үрэвслээс бусад аарцгийн хөндийн эрхтний халдварууд багтана.</p> <p>Дараах ерөнхий шинж тэмдгүүд илэрнэ.</p> <ul style="list-style-type: none"> • 38 хэм ба түүнээс дээш халуурах. • Хэвлийгээр өвдөх. • Дотор муухайрах, бөөлжинө. • Дизурийн шинж илэрнэ. • Мэс заслын үед идээт буглаа, халдварын шинж илэрнэ. 	<p>1. Эндометритийн үед:</p> <p>Амьд сорьцын шинжилгээ (биопси), мэс заслын явцад болон хатгалт хийж авсан сорьцонд эмгэгтөрөгч нян илэрнэ.</p> <p>4. Үтрээний арын хүнхрээний үрэвслийн үед:</p> <ul style="list-style-type: none"> • Арын хүнхрээний орчмын эдийн болон үрэвслийн шингэний сорьцод нян ургана. <p>4. Нөхөн үржихүйн эрхтний бусад халдваруудын үед:</p> <ul style="list-style-type: none"> • Халдвартай хэсгийн эд болон үрэвслийн шингэний сорьцонд нян ургана. • Цусанд нян ургана.

2.13. Эх, нярайг халдвараас сэргийлэх

2.13.1. Амаржих газар, төрөх тасаг нь хүлээн авах, төрөхийн өмнөх, төрөх, төрсний дараах, нярай, дутуу нярайн тасагтай, халдварын сэжигтэй эх, нярайг тусгаарлах боломжийг бүрдүүлэн, халдвараас сэргийлэх заавар, журмуудыг чанд мөрдөн ажиллана.

2.13.2. Эх, нярайд өдөр тутам үзлэг хийж халдварын сэжигтэй эх, нярайг эрт илрүүлж, яаралтай тусгаарлан халдвар тархахаас сэргийлэх арга хэмжээ авна.

2.13.3. Төрөх, мэс ажилбар, нярайн өрөөний тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тухайн тасагт ажиллаж буй сувилагч хариуцан хийнэ.

2.13.4. Биеийн шингэн, салст, шарх, шалбархайтай арьстай хүрэх, нярайг хуурайлах, живх солих, бохирдсон материалтай харьцах бүрд нэг удаагийн бээлий өмсөнө.

2.13.5. Төрөлт удирдахдаа ариун бээлий өмсөнө.

2.13.6. Төрөх үйл явц эхэлсэн халдварт өвчтэй болон сэжигтэй (биеийн халуун 37 хэмээс дээш, ураг орчмын шингэн шүүрч гараад 12 цагаас дээш болсон, нянгийн болон вирусын гаралтай халдвартай нь шинжилгээгээр батлагдсан, хяналтын хуудасгүй, төрөх үйл ажиллагаа эмнэлгийн бус орчинд явагдсан, шинж тэмдэггүй боловч шээсэн дэх нянгийн тоо 10^5 нянгийн ургалттай, халдварын болон халдварын бус гаралтай арьсны өвчтэй, шимэгч хорхойн тээгч, амьсгалын дээд, доод замын хурц үрэвсэлтэй, ураг эх дотроо эндсэн гэх мэт) эхчүүдийг тусгаарлах өрөөнд төрүүлэх боломжоор хангасан байна.

2.13.7. Төрөлт бүрийн дараа орыг цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

2.13.8. Нярайг заавар журмын дагуу дархлаажуулж, эхэд гарын эрүүл ахуй, хувийн ариун цэвэр сахих зөвлөмж өгнө.

2.13.9. Нярайд хэрэглэх тоног, төхөөрөмж, багаж хэрэгслийг халдваргүйжүүлэхэд аль болох хоруу чанар багатай бодисыг сонгон хэрэглэнэ. Фенол агуулсан халдваргүйжүүлэх бодис хэрэглэхгүй.

2.13.10. Нярайг өөр эхэд дамжуулан хөхүүлэхийг хориглоно.

2.13.11. Амаржих газар, төрөх, нярайн тасгуудыг жил бүр хэсэгчлэн буюу бүрэн хааж засвар, их цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийнэ.

2.13.12. Эх, нярай сахиуртай бол сахиурын хувийн ариун цэвэрт хяналт тавьж зөвлөгөө өгнө.

2.14. Халдвартай эх, нярайд тусламж үзүүлэх үед халдвараас сэргийлэх дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

	Халдвар	Авах арга хэмжээ
1	Эмэнд тэсвэртэй бичил биетний халдвартай эх, нярай	<ul style="list-style-type: none">• Тусгаарлана. Нярайн тасаг тусдаа бол бусад нярайгаас 2 метрээс багагүй зайд тусгаарлана.• Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ• Эх, нярайг хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө

	(VRE, MRSA)	
2	Салхинцэцэг	<ul style="list-style-type: none"> • Тусгаарлана. • Агаар дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ. • Эх салхинцэцгийн халдвартай нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед эх, нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй • Эхэд төрөхөөс 5 хоногийн өмнө, төрсний дараа 48 цагийн дотор эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн бол нярайд Варцелло зостерийн иммуноглобулин (VZIG) тарина. • Нярайг хөхөөр хооллохыг зөвшөөрнө • Нярай салхинцэцгийн халдвартай үед ээж дархлаатай бол эх, нярайг хамт байхыг зөвшөөрнө • Дархлаатай эрүүл мэндийн ажилтан тусламж үзүүлнэ.
3	Аденовирусээр үүсгэгдсэн нүдний салстын үрэвсэл	<ul style="list-style-type: none"> • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ • Алчуур, самбай, асаргаа, сувилгааны хэрэгслийг хамт хэрэглэхгүй • Эх нь аденовирусээр үүсгэгдсэн нүдний салстын үрэвсэлтэй нярай эрчимт эмчилгээ хийлгэж байгаа бол эхтэй нь хамт байлгахгүй, сүүг сааж хэрэглэнэ. • Нярай аденовирусээр үүсгэгдсэн нүдний салстын үрэвсэлтэй, эх эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө.
3	Суулгалт (Нян, вирус, C. difficile –р үүсгэгдсэн)	<ul style="list-style-type: none"> • Ариун цэврийн өрөөтэй өрөөнд тусгаарлана. • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ • Эх нь суулгалттай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед эхийн эмнэлзүйн шинж тэмдэг арилснаас хойш 48 цаг хүртэл нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. Нярай эрүүл бол хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлэн эхтэй хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. • Нярай суулгалттай, эх нь эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. • Нярайг хуурайлах, өлгийдөх бүрт хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлэн ажиллана
4	Энтеровирусийн халдвар	<ul style="list-style-type: none"> • Тусгаарлана. • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ • Эх нь энтеровирусийн халдвартай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед эхийн эмнэлзүйн шинж тэмдэг арилах хүртэл эх, нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. Нярай эрүүл бол хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлэн эхтэй хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. • Нярай энтеровирусийн халдвартай, эх нь эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө
5	Эх вируст гепатит А-ийн халдвартай	<ul style="list-style-type: none"> • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ • Нярайд иммуноглобулин хийнэ • Эх, нярайг хавьтал болох, хөхөөр хооллохыг зөвшөөрнө.
6	Энгийн херпес	<ul style="list-style-type: none"> • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ • Нярайд шинж тэмдэггүй хэлбэрийг илрүүлэх үзлэг хийнэ • Эх, нярайг хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө • Хөхний толгой дээр байрлалтай бол хөх хөхүүлэхгүй цэврүүг хагалахгүйгээр сааж хэрэглэнэ.

		<ul style="list-style-type: none"> • Ам, уруулын салст дээр байрлалтай бол нярайг үнсэхийг хориглоно.
7	Тархмал хэлбэрийн Херпес зостерийн халдвар	<ul style="list-style-type: none"> • Тусгаарлана. • Агаар дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ. • Эх нь херпес зостерийн халдвартай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед эхийн эмнэлзүйн шинж тэмдэг арилах хүртэл эх, нярайг хамт байхыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ.
8	Томуу болон амьсгалын замын вирусийн халдвар	<ul style="list-style-type: none"> • Тусгаарлана. • Агаар дусал, хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ. • Эх халдвартай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед эх, нярайг хамт байхыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. Нярай эрүүл бол эх мэс заслын амны хаалт зүүж хамт байхыг зөвшөөрнө. • Нярайд хүрэхдээ гарын эрүүл ахуйг сахина. • Нярай халдвартай, эх нь эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө
9	Улаанбурхан	<ul style="list-style-type: none"> • Тусгаарлана • Агаар дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ • Улаан бурхны дархлаажуулалтанд хамрагдсан эмнэлгийн ажилтан ажиллана. • Нярайд иммуноглобулиныг зааврын дагуу хэрэглэнэ. • Эх нь халдвартай нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед тууралт гарснаас хойш 4 өдөр өнгөртөл эх, нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. Нярай эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. • Нярай халдвартай үед эх дархлаатай бол эх, нярайг хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө • Нярай халдвартай, эх халдварын сэжигтэй байгаа бол нууц үеийн хугацаа дуустал хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрөхгүй
10	Менингит (Neisseria meningitidis, haemophilus influenzae)	<ul style="list-style-type: none"> • Дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ. • Нянгийн эсрэг эмчилгээ эхэлснээс хойш 24 цаг хүртэл хугацаанд тусгаарлана. • Нянгийн эсрэг эмчилгээ эхэлснээс 24 цагаас хойш эх, нярайг хамт байх, хөхөөр хооллох эсэхийг шийдвэрлэнэ.
11	Гахай хавдар	<ul style="list-style-type: none"> • Тусгаарлана • Дусал, хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ. • Гахай хавдрын дархлаажуулалтанд хамрагдсан эмнэлгийн ажилтан ажиллана. • Эх нь халдвартай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед паротит эхэлснээс 9 өдөр хүртэл эх, нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. Нярай эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө • Нярай халдвартай, эх нь дархлаатай бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. Эхэд халдварын сэжиг байгаа бол сүүг сааж хэрэглэнэ.
12	Хөхүүл ханиад	<ul style="list-style-type: none"> • Тусгаарлана • Дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ • Эх нь хөхүүл ханиадтай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед нянгийн эсрэг бэлдмэлээр сэргийлэлт

		<p>хийж 5 өдөр болтол эх, нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. Нярай эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. Нярайд 2 м-ээс дотогш зайд ойртох, хүрэх бол эх мэс заслын амны хаалт, гарын эрүүл ахуйг сахина.</p> <ul style="list-style-type: none"> • Нярай нь хөхүүл ханиадтай, эх эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө
13	Улаанууд	<ul style="list-style-type: none"> • Тусгаарлана. • Дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ. • Улаануудын дархлаажуулалтанд хамрагдсан эмнэлгийн ажилтан ажиллана. • Эх улаануудтай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед тууралт гарснаас хойш 7 өдөр болтол эх, нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. Нярай эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. • Нярай улаануудтай бол эх, нярайг хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө
14	А бүлгийн стрептококкийн халдвар	<ul style="list-style-type: none"> • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ. • Нянгийн эсрэг эмчилгээ эхэлснээс хойш 24 цаг хүртэл хугацаанд тусгаарлана. Эмчилгээний үр дүнг харгалзана • Эх, нярайг хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө.
15	Тэмбүү	<ul style="list-style-type: none"> • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ • Эх тэмбүүтэй бол эмчилгээ эхэлснээс 24 цагийн дараагаас хөхөөр хооллох, эх, нярай хамт байхыг зөвшөөрнө • Төрөлхийн тэмбүүтэй нярайг эхтэй нь хамт байлгах, хөхөөр хооллохыг зөвшөөрнө.
16	Халдвартай хэлбэрийн сүрьеэ	<ul style="list-style-type: none"> • Тусгаарлана. • Агаар дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ. • Халдвартай үеийг дуустал эх, нярайг хамт байхыг зөвшөөрөхгүй • Сүүг сааж хэрэглэх боломжтой.
17	ХДХВ, ДОХ	<ul style="list-style-type: none"> • Эх, нярайг хамт байхыг зөвшөөрнө. • Хөхөөр хооллохыг зөвшөөрөхгүй.
18	Цитомегаловирусын халдвартай	<ul style="list-style-type: none"> • Тусгаарлана. • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ. • Эх цитомегаловирусын халдвартай бол хөхөөр хооллохыг зөвшөөрөхгүй. • Нярай цитомегаловирусын халдвартай бол эх, нярайг хамт байх, хөхөөр хоолохыг зөвшөөрнө. • Вирус шээсээр их ялгардаг тул нярайн живхтэй солихдоо анхаарах
19	Эх вируст гепатит В-ийн халдвартай	<ul style="list-style-type: none"> • Эх, нярайг хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. • Нярайд 12 цагийн дотор вируст гепатит В-ийн эсрэг вакцин, иммуноглобулиныг тус тусад нь тарина. • Нярайг цаашид дархлаажуулалтын хөтөлбөрийн дагуу вакцинжуулна. • Товлолт вакцинд бүрэн хамрагдсаны дараа үр дүнг хянана. • Эх В гепатитын архаг халдвартай бол төрөхөөс өмнө вирус дарангуйлах эмчилгээ хийлгэнэ.
20	Хамуу	<ul style="list-style-type: none"> • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ • Эхийг яаралтай эмчилсэний дараа нярайтай хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө.

21	Бөөс	<ul style="list-style-type: none"> • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ • Нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед эхийг эмчлэгдэх хүртэл хавьтал болохыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. • Нярай эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө.
----	------	---

Гурав. Диализ эмчилгээ тогтмол хийлгэж байгаа үйлчлүүлэгчид тавих тандалт, халдвараас сэргийлэх

3.1. Диализ эмчилгээнд тогтмол хамрагдаж байгаа үйлчлүүлэгчид судасны гуурстай холбоотой, цусаар дамжих, эмэнд тэсвэртэй бичил биетний халдвар илрүүлэх тандалт хийнэ.

3.2. Гепатитын С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд 6 сар тутам, Гепатитын В вирусийн эсрэг дархлаагүй бол HBsAg илрүүлэх шинжилгээнд 6 сар тутам, Метициллин тэсвэртэй стафилококк ауриус (MRSA), өргөтгөсөн үйлдэлтэй беталактамаза ялгаруулдаг (ESBL) грам сөрөг бактерийн халдвар илрүүлэх шинжилгээнд жилд 1 удаа тус тус хамруулна.

3.3. Диализ эмчилгээнд тогтмол ордог үйлчлүүлэгч үжил, бактеремия, хэсэг газрын үрэвсэлт халдвар, хэвлийн диализд орсон үйлчлүүлэгч хэвлийн гялтангийн үрэвслээр хүндэрсэн тохиолдлыг бүртгэж мэдээлнэ.

3.4. Үйлчлүүлэгчийг эмчилгээ эхлэхийн өмнө В, С вируст гепатит, ХДХВ, ванкомицинд тэсвэртэй энтерококк, метициллин тэсвэртэй стафилококкын халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулж, В вируст гепатитын архаг халдваргүй, дархлаажуулалт хийлгээгүй, эсвэл хийлгэсэн боловч Anti-HBs –ийн титрийн хэмжээ <10 mIU/ml тохиолдолд В вируст гепатитын эсрэг 3 тун вакцинаар дархлаажуулна.

3.5. Дархлаажуулалтын дараа дархлал тогтоцын түвшинг тодорхойлуулж өвчний түүхэнд тэмдэглэнэ.

3.6. Диализ хийлгэж байгаа үйлчлүүлэгчийн эмчилгээний хуудсанд хэрэглэсэн диализын аппаратны дугаар, диализын аппарат холбосон болон салгасан ажилтны нэрийг тэмдэглэсэн байна.

3.7. Диализын үед эрүүл мэндийн ажилтан гарын ариун цэврийг сахин, амны хаалт бээлийг өмсөн, үйлчлүүлэгчид амны хаалтыг зүүлгэнэ.

3.8. Үйлчлүүлэгчийн хатгалт хийх хэсгийг 2%-ийн хлоргексидин глюконат, 70% изопропил болон этилийн спирт эсвэл 10% -ийн повидион иодын аль нэгээр халдваргүйжүүлнэ.

3.9. Гемодиализын аппарат, багаж хэрэгслийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу цэвэрлэж, халдваргүйжүүлнэ. Давтан хэрэглэх цус цэвэршүүлэн шүүх (dialyser) хэсгийг цэвэрлэгээ угаалга, дээд зэргийн халдваргүйжүүлэлт хийж ариун усаар зайлж хатаан бохирдлоос сэргийлж хадгална.

3.10. Диализын аппаратын ус хадгалах танк, усны шүүлтүүр бохирдохоос сэргийлж тогтсон хугацаанд солино.

3.11. Цус шүүх, цэвэршүүлэх эмчилгээнд нэг удаагаар хэрэглэгдэх багаж хэрэгслийг хэрэглэсэн даруйд устгана.

3.12. Тарилгын аюулгүй байдал алдагдахаас сэргийлж олон туншил эм биобэлдмэлийг хэрэглэх явцад бохирдуулахаас сэргийлнэ. Аль болох нэг удаагийн

туншил бүхий эм биобэлдмэлийг хэрэглэх, эм биобэлдмэлийн таглааг спиртээр халдваргүйжүүлсний дараа зүүг хатгах, ариун зүү тариурыг нэг удаагаар хэрэглэнэ.

3.13. Эрүүл мэндийн ажилтнуудад диализтай үйлчлүүлэгчийн халдварын эрсдэлт хүчин зүйл, эсрэг заалт, халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээний талаар сургалт хийнэ.

Дөрөв. Цусны хавдартай, дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэж байгаа үйлчлүүлэгчид тавих тандалт

4.1. Тогтмол эмчилгээнд хамрагдаж байгаа үйлчлүүлэгчийг цусаар дамжих гепатитийн В, С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулна.

4.2. Цусны хавдартай хүүхэд, дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэж байгаа үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн ажилтан нь томуу, томуу төст өвчин бусад агаар, дуслын замаар дамждаг халдварын шинж тэмдэгтэй бол ажиллуулахгүй.

4.3. Улаанбурханы халдварын дэгдэлт гарсан үед улаанбурханы халдварын тохиолдолтой хавьтал болсон дархлаагүй эрүүл мэндийн ажилтанг ажиллуулахгүй.

4.4. Эрхтэн шилжүүлэн суулгасан үйлчлүүлэгчийг гаднаас халдвар авахаас сэргийлэн агаарын сөрөг даралттай өрөөнд нэмэлт сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

4.5. Тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн ажилтан нь томуу, томуу төст өвчин бусад агаарын, дуслын, хавьтлын замаар дамждаг халдварын шинж тэмдэгтэй бол ажиллуулахгүй.

4.6. Эмнэлгийн орчноос халдвар авах эрсдлийг хянаж өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 11 сарын 29 -ны
өдрийн 9539 дугаар тушаалын
долоодугаар хавсралт

ГЕПАТИТЫН В, С ВИРУСИЙН ЦОЧМОГ ХАЛДВАРЫН ТОХИОЛДОЛД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАМААРЛЫГ ТАНДАХ ЗААВАР

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гепатитын В, С вирусийн цочмог халдвар, D вирусийн шинэ халдварын улмаас эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгч халдвар авч болох нууц үеийн хугацаанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан бол халдвар дамжих эрсдэлд тандалт, судалгаа хийхэд энэхүү зааврыг мөрдөнө.

1.2. Гепатитын В, С вирусийн цочмог халдвар, D вирусийн шинэ халдвараар оношлогдон хэвтэн эмчлүүлэх, үйлчлүүлж байгаа тохиолдол бүрийг эмчлэгч эмч тархвар судлаач эмчид мэдээлнэ.

1.3. Тархвар судлалын судалгаагаар халдвар авч болох хугацаанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан бол тухайн эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой эсэхэд тандалт, судалгаа хийнэ.

Хоёр. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний холбогдолд тандалт хийх

2.1. Үйлчлүүлэгчийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан хугацаа нь халдварын нууц үеийн хугацаатай нийцэж байгаа эсэхийг нягтлан тохирч байвал судалгааг хийнэ.

2.2. Лабораторийн шинжилгээний үзүүлэлт нь тухайн халдварын оношилгооны удирдамж дахь шинэ халдвар илтгэх шалгуурт тохирч байгаа эсэхийг нягтлана.

2.3. Асуумж судалгаа, лабораторийн үзүүлэлтээр тухайн эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээтэй холбоотой байх эрсдэлтэй бол тухайн эмнэлгийн халдвары сэргийлэлт, хяналтын байдалд тандалт судалгаа хийнэ. Үүнд:

2.3.1. Тухайн ажилбарын гүйцэтгэх явцад халдвараас сэргийлэх үйл ажиллагаа алдагдаж байгаа эсэх;

2.3.2. Багаж, хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалын үйл ажиллагаа;

2.3.3. Эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл ахуй сахилт;

2.3.4. Эмнэлгийн орчны цэвэрлэгээ;

2.3.5. Нэг удаагийн багаж, хэрэгслийг давтан ашиглаж байгаа эсэх

2.3.6. Тухайн эмнэлгээр үйлчлүүлсэн хүмүүсийн бүртгэлээс В, С, D вирусийн архаг халдвартай үйлчлүүлэгч эмнэлгийн тусламж авсан эсэх

2.4. Тухайн эмнэлэгт халдварын эрсдэлт хүчин зүйл байгаа бол зөвлөмж өгнө.

2.5. Тандалт судалгаагаар 1 эмнэлэгт тусламж, үйлчилгээ авсан 2-оос дээш В, С, D вирусийн шинэ халдварын тохиолдол бүртгэгдвэл лаборатори, эмнэлзүй, тархвар судлаач эмч нарын оролцоотой судалгааны баг гаргаж зорилтод тандалт судалгааг хийнэ.

2.6. Үйлчлүүлэгчээс асуумж судалгааг дараах асуумжаар авна.

2.6.1. Амбулаториор тусламж, үйлчилгээ авсан эсэхийг тодруулна;

2.6.2. Эмнэлэгт хэвтэж тусламж, үйлчилгээ авсан эсэх;

2.6.3. Ажил мэргэжилтэй холбоотой эрсдэл байгаа эсэх;

2.6.4. Гэрээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан эсэх;

2.6.5. Эмнэлгийн бус эрсдэл (гоо сайхан, шивээс, маникюр, педикюр, сауны бие үрэх үйлчилгээ, үс хуулах гэх мэт) байгаа эсэх;

2.6.6. Хувь хүний зан үйлтэй холбоотой эрсдэл байгаа эсэхийг тус тус тодруулна.

Гурав. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын сэжигтэй тохиолдлоор бүртгэх шалгуур

3.1. Доорх шалгуурын дагуу үнэлгээ хийж бүх шалгуурыг хангаж байвал эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын сэжигтэй тохиолдлоор бүртгэнэ.

3.1.1. Тухайн тусламж, үйлчилгээ авахаас өмнөх шинжилгээнд HCV –RNA сөрөг, HBsAg сөрөг, HBsAg эерэг - HDV сөрөг

3.1.2. Халдвар авсан байж болох хугацаа нь тохирсон.


3.1.3. Лабораторийн биохими, маркерийн шинжилгээний үзүүлэлт нь тухайн халдварын оношлогооны удирдамж дахь шинэ халдвар илтгэх шалгуурт тохирсон.

3.1.4. Эмчлэгч эмч цочмог халдвар гэж оношилсон.

3.1.5. Тархвар судалгаагаар тухайн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээ авах үед халдвар авах эрсдэлт хүчин зүйл байсан.

3.1.6. Тархвар судлалын асуумжаар бусад эрсдэлт хүчин зүйлд өртөөгүй.

ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг мэдээлэх урсгал



ЭТҮХХ-ын тандалтыг мэдээлэх хуудас

ЭМБ-ын нэр.....

Тандалт хийсэн он.....сар.....

Тусламж, үйлчилгээний төрөл		Тухайн ажилбар хийлгүүлсэн үйлчлүүлэгчийн тоо	ЭТҮХХ-ын тандалт хийсэн үйлчлүүлэгч (бодит тоо)	ЭТҮХХ-ын сэжигтэй тохиолдол (бодит тоо)	ЭТҮХХ-ын батлагдсан тохиолдол (бодит тоо)	Бичил амь судлалын шинжилгээнд хамрагдсан тоо	Халдварт өртөлтийн хувь	Өвчний онош ОУ-ын 10-р ангилалаар	Нас баралт (бодит тоо)	ЭТҮХХ-тай холбоотой эмнэлгийн нэр
1	Мэс засал	Мэс засал								
		Үүнээс давтан мэс засалд орсон								
		Мэс ажилбар								
3	Нийт нярайн тоо									
4	Үүнээс эмчилгээтэй нярай									
5	Төрөх замаар төрсөн эх									
6	Мэс заслаар төрсөн эх									
7	Амьсгалын аппараттай хүн/өдөр									
8	Шээлгүүртэй хүн/өдөр									
9	Судасны гуурстай хүн/өдөр									
10	Диализ эмчилгээ хийлгэсэн хүний тоо									
11	Бусад									

ЭТҮХХ-ын сэжигтэй тохиолдлыг бүртгэх, мэдээлэх загвар

Үзүүлэлт	Тохиолдол 1	Тохиолдол 2...
ЭТҮХХ-ын сэжигтэй тохиолдол		
Тусламж, үйлчилгээ үзүүлсэн ЭМБ нэр		
Үйлчлүүлэгчийн овог нэр / (Нярайн бол эхийн нэр)		
Нас, хүйс, регистрийн дугаар		
Гэрийн хаяг/ утасны дугаар		
Тусламж, үйлчилгээний нэр		
Тусламж, үйлчилгээг тухайн сард авсан нийт тоо		
Тусламж, үйлчилгээ авсан огноо		
Халдварын шинж тэмдэг илэрсэн огноо		
Илэрсэн халдварын шинж тэмдэг		
Бичил биетэн илрүүлэх шинжилгээнд сорьц авсан хугацаа		
Илэрсэн үүсгэгчийн нэр, антибиотик мэдрэг чанар		
Мэдээлсэн эмнэлгийн нэр / ажилтан		

ЭМА-ны халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртөлтийг мэдээлэх загвар

Өртөлтийн хэлбэр	Эрсдэлт хүчин зүйлд өртсөн тохиолдлын тоо	Үүнээс			Халдвараас сэргийлж авсан арга хэмжээ		
		Эмч	Сувилагч	Бусад	Дархлаа жуулалт	Эмийн эмчилгээ	Шинжилгээнд хамруулсан
Хэрэглэсэн зүү, иртэй багаж хэрэгсэлд өртсөн							
Салстад биеийн шингэн үсэрсэн							
Бусад							

Дундаж хатгалтыг мэдээлэх загвар

	Нийт үйлчлүүлсэн хүний тоо	Хатгалтын тоо	Дундаж хатгалт

**Эмнэлгийн ажилтны В,С,Д вирусийн халдварын илрүүлэг, сэргийлэлт, өртөлтийг
мэдээлэх хүснэгт (жилд 1 удаа)**

№	Үзүүлэлт	ЭМА-ны тоо
1.	Эмнэлгийн нийт ажилтны тоо	
2.	В, С, D вирус гепатитын халдвартай эмнэлгийн ажилтны тоо:	
3.	Тухайн жилд шинээр ажилд орсон ЭМА-ны тоо	
	Үүнээс гепатитын В вирусийн халдвартай ЭМА-ны тоо	
	Үүнээс гепатитын С вирусийн халдвартай ЭМА-ны тоо	
	Үүнээс гепатитын D вирусийн халдвартай ЭМА-ны тоо	
	Үүнээс гепатитын В, С вирусийн хавсарсан халдвартай ЭМА-ны тоо	
	Үүнээс гепатитын В, D вирусийн хавсарсан халдвартай ЭМА-ны тоо	
	Үүнээс гепатитын В, С D вирусийн хавсарсан халдвартай ЭМА-ны тоо	
4.	Гепатитын вирусийн илрүүлэг шинжилгээнд хамрагдсан ЭМА-ны тоо	
	Шинээр гепатитын В вирусийн халдвар илэрсэн ЭМА-ны тоо	
	Шинээр гепатитын С вирусийн халдвар илэрсэн ЭМА-ны тоо	
	Шинээр гепатитын D вирусийн халдвар илэрсэн ЭМА-ны тоо	
	Шинээр гепатитын В, С вирусийн хавсарсан халдвар илэрсэн ЭМА-ны тоо	
	Шинээр гепатитын В, D вирусийн хавсарсан халдвар илэрсэн ЭМА-ны тоо	
	Шинээр гепатитын В, С,D вирусийн хавсарсан халдвар илэрсэн ЭМА-ны тоо	
5.	Гепатитын В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулагдсан ЭМА-ны тоо	
	Нэг дэх тунд хамрагдсан ЭМА-ны тоо	
	Хоёр дах тунд хамрагдсан ЭМА-ны тоо	
	Гурав дах тунд хамрагдсан ЭМА-ны тоо	
6.	Гепатитын В вирусийн эсрэг дархлал тогтоцыг тодорхойлуулсан ЭМА-ны тоо	
	Anti-HBs 10IU/ml –ээс бага гарсан ЭМА-ны тоо	
	Anti-HBs 10IU/ml –ээс дээш гарсан ЭМА-ны тоо	
7.	Тухайн жилд цус болон биологийн шингэнд өртсөн ЭМА-ны тоо	
	Үүнээс гепатитын В вирусийн халдвараар халдварлагдсан ЭМА-ны тоо	
	Үүнээс гепатитын С вирусийн халдвараар халдварлагдсан ЭМА-ны тоо	
	Үүнээс цусаар дамжих бусад халдвараар халдварлагдсан ЭМА-ны тоо	
8.	Жилд гепатитын В, С вирусийн идэвхижил тодорхойлуулсан ЭМА-ны тоо	
	Вирусын эсрэг эмчилгээнд орсон ЭМА-ны тоо (В,С)	
	Үүнээс гепатитын В,С вирусын идэвхижил >10GE/ml гарсан ЭМА-ны тоо	
	Үүнээс ажлын байрны зохицуулалт хийгдсэн ЭМА-ны	

**Ариутгал, халдваргүйтгэлд ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн
судалгаа ирүүлэх загвар**

Д/д	Тоног төхөөрөмж ийн нэр	Үйлдвэр лэсэн улс	Марк, загвар	Хүчин чадал	Үйлдвэр лэсэн он	Ашиглалт ад орсон он	Ашиглалт ын байдал/ үнэлгээ	Ханган нийлүүлсэн санхүүгийн эх үүсвэр

**Ариутгал, халдваргүйжүүлэлтэд хэрэглэж байгаа
бодисын судалгаа ирүүлэх загвар**

Д/д	Бодисын нэр	Үйлдвэрлэсэн улс	Тухайн жилд ханган нийлүүлсэн хэмжээ	Тухайн жилд хэрэглэсэн хэмжээ
1.	Гадаргуугийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд			
2.	Багажны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалд			
3.	Гарын халдваргүйжүүлэлтэд			
4	Арьсны талбайн халдваргүйжүүлэлтэд			